

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК



СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМ ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР
МУ-12219А, МУ-15249А
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-2641984/

Хянасан:
БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын
мэргэжилтэн

Биелэлтийг тайлагнасан:
“Цемент шохой” ХХК-ийн Гүйцэтгэх
захирал.....

“Цемент шохой” ХХК-ийн БОХэлтсийн
даргын үүргийг хавсран гүйцэтгэгч
БОНСэргээлтийн мэргэжилтэн.....



Шинэцэцэг

Наранбаатар

Болортуяа

Уртнасан

Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл 2023 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Хөтөлийн Цемент шохойн үйлдвэр	3
1.2 Шохойн чулууны орд	6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛ	18
5.1 ТЕХНОЛОГИЙН ХАЯГДАЛ ХУРИМТЛАГДСАН ТАЛБАЙ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:	18
5.2 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:	19
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ	19
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	26
12. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	28
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	29
14. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН ХҮРЭЭНД	32
15. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36
ДҮГНЭЛТ	39
ХАВСРАЛТ	40

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлийн “Цемент шохой” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

1.1 Хөтөлийн Цемент шохойн үйлдвэр

Хөтөлийн “Цемент шохой” ХХК нь 1983 оны 10-р сараас эхлэн 40 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус үйлдвэрийн байршил нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт, Дархан-Уул аймгаас урагш 60 км, Орхон аймгаас 120 км, Улаанбаатар хотоос 260 км зайд тус тус байрладаг.



Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Хөтөлийн шохойн чулууны ордыг түшиглүүлэн Цемент шохойн үйлдвэр барих тухай Улсын Төлөвлөгөөний комиссын шийдвэр 1978 онд гарч тухайн үеийн ЗХУ-ын Новосибирск хотын “СИБНИЙПРОЕКТ ЦЕМЕНТ” эрдэм шинжилгээний хүрээлэнд зураг төсвийг зохиож барилгын ажлыг 1981 оноос эхлүүлсэн түүхтэй.

Шохойн үйлдвэр нь жилд 65.0 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1984 оноос, Цементийн үйлдвэрийг жилд 500.0 мян.тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1985 оноос эхлэн одоог хүртэл үйлдвэрлэлээ тасралтгүй явуулж байгаа ба 2014 оноос хоногт 2500 тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн хуурай аргын үйлдвэр ашиглалтад оруулсан бөгөөд хуурай технологийн үйлдвэрийн хүчин чадал нь 500.0 мян.тн юм.

Тус үйлдвэрт нийтдээ 820 орчим ажилчид ажилладаг бөгөөд дулаан үйлдвэрлэх, хангах түгээх охин компани “Хөтөл энерги” ХХК, Чулуунцарын үйлдвэр, Цементийн үйлдвэр, Шохойн үйлдвэр, Геологи уул уурхай, Механик засвар, Эрчим зүй, Сорилт шинжилгээний лаборатори, Борлуулалт логистикийн алба, Захиргаа гэсэн үндсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Эрчим хүчний хангамж: Цахилгаан эрчим хүчийг Дархан хотоос 110 квт-ын шугамаар Хөтөлийн ГПП 110/35/6 квт-ын дэд станцид хүлээн авч Шохойн үйлдвэрийн "ТП" 2-р станциар дамжуулан хуваарилна.

Цэвэр усны хангамж: Ус хангамжийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн талбайгаас 20 км-т, Сэлэнгэ аймгийн Орхон сумаас 2,5 км зайд Орхон голын хөндийд оршино. Ус хангамжид 50-57м гүн бүхий 50-83л/сек ундаргатай 3 өрмийн цооногоос авч байна. Усны чанар, түүнийг цэвэршүүлэлтийг мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэж байна.

Ус хангамжийн сүлжээнд:

- Ус хураагуурын цооногууд
- Магистрал шугам (2 дахь өргөлтөөс үйлдвэрийн талбай хүртэл)
- 3 ба 4 өргөлтийн насосын станцууд
- Усан сан

Тус үйлдвэрт ахуйн ус хангамжид зориулсан нэгдсэн систем байгуулагдаж, бохир ус цэвэршүүлэх байгууламжид үйлдвэрийн хаягдал ус болон ахуйн ус түгээгүүр хамаарагддаг болно.


Үйлдвэрийн талбайн гаднах сүлжээ ба цэвэршүүлэлтийн байгууламжид:

- Даралтат өөрөө урсах коллектор (Үйлдвэрийн талбайгаас цэвэршүүлэх байгууламж хүртэл)
- Цэвэршүүлэлтийн насосын станц
- Цэвэршүүлэх сүлжээний байгууламжийн цогцолбор
- Цэвэршүүлсэн усны даралтат өөрөө урсах коллектор орно.

Төслөөр хэрэгжүүлсэн цэвэршүүлэх байгууламж бүхэлд нь цэвэршүүлэхээр тооцооноор хоногт 2133 м³ ба цэвэршүүлэлтийн ууршуулалтын талбайгаас 1 км зайд задгай зайлуулна.

Үйлдвэрийн бохир усны систем: Үйлдвэрлэлийн технологиос гарах пульпыг тусгай тунгаагуур, цэвэр усны сан хоёроор дамжуулан цэвэршүүлэн тунгалагжуулдаг тул үйлдвэрлэлийн технологийн хаягдал бохир ус гардаггүй. Харин ажилчдын унд ахуйн болон ариун цэврийн өрөө, халуун усны хэрэглээнээс гарсан бохир усыг хотын ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд нийлүүлэн хаядаг. Үйлдвэрийн газарт хамаарах бохир усны сүлжээний нийт урт 0,6 км. Энэ сүлжээгээр хоногт дунджаар 30 мян.м³ бохир зайлуулагдах бөгөөд хаягдаж байгаа ус нь зөвхөн ахуйн бохирдолтой юм.

Үйлдвэрийн дулааны хангамж: Үйлдвэрийн харъяа дулааны станц нь өөрийн үйлдвэрээс гадна Сайхан сумын Хөтөл хотын айл өрхүүдийг дулаанаар ханган ажиллаж байна.



Шуудан холбоо: Хөтөлийн "Цемент-шохой" ХХК нь Улаанбаатар хот болон бусад аймаг, гадаад орнуудтай шууд харилцах телефон холбоотой, мэдээллийг факсаар солилцох бүрэн боломжтой.

Чулуунцар үйлдвэрлэл нь автоматжуулсан үйлдвэр ба хоногт 2500 тонн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай.

Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал
Хос роторт бутлуур	900 тонн/цаг
Шохойн чулууны жигдрүүлэх агуулах	73,000 тонн
Булт тээрэм	210 тонн/цаг
Эргэх зуух Ø-4м, 60м	2,500-3,000 тонн/цаг
Нүүрсний тээрэм	18-20 тонн/цаг
Цементийн тээрэм 3 ширхэг	3×50 тонн/цаг
Нүүрсний жигдрүүлэн нуруулдах агуулах	15,000 тонн
Цементийн силос	16,000 тонн
Цементийн савлах машин 3 ширхэг	300 тонн/цаг

Шохойн үйлдвэрлэл нь жилд 65 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус цех нь хоногт 70 тн бүтээмжтэй ажиллах шохойн чулууг шатаах 3 зуухтай. 0-3 мм ширхэглэлээр нарийн бутлагдсан 70%-иас доошгүй идэвхжилтэй шохойг жилд 65 мян.тн гаргахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилүүдэд нунтаг шохой, сүүлийн жилүүдэд 80%-иас доошгүй идэвхжилтэй бүхэл шохойг үйлдвэрлэн Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т нийлүүлж байна.

1.2 Шохойн чулууны орд

1961 онд Дарханы районд хийгдсэн 1:200000 масштабтай эрэл зураглалын ажлаар Орхон голоос зүүн урагш 25км-т протерозойкембрийн элсэн чулуу, занарын дунд шохойн чулууны линз хэлбэрийн биетийг илрүүлсэн. 1962 онд тус районд хийгдсэн 1:25000 масштабтай эрлийн ажлын үр дүнд шохойн чулууны хэд хэдэн линз илрүүлсэн. Линз ирүүлснээс Хөтөлийн шохойн чулууны орд юм. Шохойн чулуу нь суналын дагуу 2750м баруун урагшаа 45-50 градус суналттай, биетийн зузаан нь 100м гэж тогтоожээ. Мөн 2014 онд Андреев А.А шохойн чулууны илэрц дээр геологийн урьдчилсан хайгуулын ажил хийж ордын төв хэсгийг В-С1 зэргээр зүүн ба баруун жигүүрийг С1-С2 зэргээр нөөцийг тогтоосон.

Орд нь геологийн тогтцын хувьд хувиралд орсон элсэн чулуу, занар, шохойн чулуунаас тогтох бөгөөд профиритын дайгаар хэрчигдэж дөрөвдөгчийн сэвсгэр хуудсаар хучигдсан байна.


Хөтөлийн шохойн чулууны орд нь структурын харьцааны хувьд антикналь атираажлийн өмнөд жигүүрийн хэсэгт профиритын дайга болон тектоникийн эвдрэлтэй орон зайн хувьд холбоотойгоор үүссэн. *Ордын геологийн литологийн зүсэлтийг үзүүлбэл:*

1. Элсэн чулуу бараан саарал өнгөтэй, янз бүрийн ширхэглэлтэй уналтын азумит 170-190°
2. Шохойн чулуу саарал өнгөтэй, гантигжсан, доломитлогжих процесс орсон, СаО 34%, MgО 14%, хурдасны зузаан 30м. Занар хлоржих процесст орсон ногоовтор туяатай, бараан саарал өнгөтэй, үзэгдэх зузаан нь 20-30м.
3. Шохойн чулууны доод дээд хэсэг нь цайвар саарал өнгөтэй, гантигжсан зузаалгын дунд хэсэгт нь саарал өнгөтэй, жижиг ширхэгтэй шохойн чулуу, доломитжих процесст бага зэрэг орсон MgО-1.5-3.0%.
4. Хурдаслаг чанар хлоржих процесст орсон ногоовтор өнгөтэй, бараан саарал туяатай, үзэгдэх зузаан нь 100м шохойн чулууны үеийг хучиж байрласан. Ордын нийт талбай нь элсэн чулуу, занар, шохойн чулууны хэмхдэс материал агуулсан боровтор саарал өнгийг дөрөвдөгчийн хурдасаар хучигдсан байна. Энэ хурдасны зузаан нь 0.5-12м.

Шохойн чулууны орд нь засаг захиргааны хуваарилалтаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт "Шохойн нуруу" хэмээх газарт байрлах ба ашиглалт явуулах МУ-12219А, МУ-15249А тоот зөвшөөрлийн талбайд байрлана.

Тус орд нь газар зүйн байрлалаараа Монгол орны Хангайн уулын бүсэд хамаарагдах ба, далайн түвшнээс дээш 1000-1500 м өндөрт өргөгдсөн хэсэгт оршино.

Хөтөл-1 ордын шохойн батламжлагдсан үйлдвэрлэлийн нөөц 1980 оны 11-р сарын 3-ны байдлаар В+С1 зэрэглэлээр 47,6 сая.тн, үүнээс шохойн түүхий эд 14,8 сая.тн ба цементийн 32,8 сая.тн болно. Төмөр толгойн ордын төмрийн хүдрийн нөөц В+С1 зэрэглэлээр 3,7 сая.тн байгаа нь тус үйлдвэрийг 50 жил хангахад хүрэлцээтэй юм. Тус үйлдвэрийн хэрэгцээнд зориулсан шохойн чулууны ил уурхайн хүчин чадал жилд 1015 мян.тн, үүнээс 790 мян.тн нь шохой,



цемент болон товарын шохойн чулуу үйлдвэрлэх сайн чанарын шохойн чулуу бөгөөд 225 мян.тн нь цемент үйлдвэрлэлийн зориулалттай карбонат багатай шохойн чулуу байна.

Урьдчилсан хайгуулыг явуулахдаа баганат өрөмдлөг, суваг, шурф малталтын ажил хийж, нөөцийг +940-р түвшин хүртэл тогтоожээ. Тус ордыг түшиглэж жилдээ 500.0 мян.тн 400 маркийн портланд цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэр, 65 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай шохойн үйлдвэр барих болсонтой холбогдуулан 1975-1976 онд барилгын материалын экспедицийн №7 анги нарийвчилсан хайгуул хийсэн.

Шохойн чулууны ордыг геологийн тогтоц хэмжээ чанараас хамааруулж 2-р группт хамааруулжээ. Хайгуулын шугамуудын хоорондын зайг В зэргээр нөөц бодсон талбайд 90-160м-р С1 зэргээр нөөц бодсон талбайд 180-340м-р авчээ.

1976 онд Хөтөлийн шохойн чулууны орд дээр 23 цооног буюу 2035 уртааш метр өрөмдлөгийн ажил хийжээ. 1980 онд Ш.Доржсүрэн, К.Ш.Фаткуллан, С.Н.Кальсан нар 1962-1963, 1975-1976 онуудын урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлын тайлангийн материал хими шинжилгээний үр дүнг үндэслэн барилгын шохой үйлдвэрлэх чиглэлээр нэмэлт судалгаа хийж гүйцээх судалгааны тайлан бичсэн байна. Үүний үр дүнд ордын нөөцийг 1980 оны 01-р сарын 01-ний байдлаар УАМНК-оор батлуулжээ. Ордыг ашиглах явцад 1980 оны дээрх батлагдсан нөөцийн чанар, тоо хэмжээ, хил

хязгаарт өөрчлөлт их хэмжээгээр гарч, нөөц тооцож үйлдвэрийг түүхий эдээр хангахад хүндрэл учирснаас тэр үеийн үйлдвэрийн захиргаа 1988 онд Улсын Барилгын Хороонд /УБХ/ Хөтөл-1 ордын төв хэсэгт гүйцээх хайгуул, нөөц Хөтөл-2 ордод нарийвчилсан хайгуул хийлгэх хүсэлт тавьснаар уг ордын ашиглалт эхэлсэн.

1992 онд Эрдэнэтийн УБҮ-ийн хайгуулын ангид ашиглалтын хайгуул хийлгэх захиалга өгч дээрх захиалгын дагуу ордын төв хэсэгт хайгуулын шугам 1-ээс 22-ын хооронд өөрөөр хэлбэл ордын баруун талын II шугамаас зүүн талын III шугамын хооронд +930-р түвшин хүртэл нарийвчилсан хайгуулын схемээр ашиглалтын хайгуул өөрийн хөрөнгөөр хийж ойрын жилүүдэд ашиглах ашигт малтмалын геологийн тогтоц, тоо хэмжээ, хил хязгаарыг тогтоож, нарийвчилсан хайгуулын нөөцийн баталгааг дүгнэж, тодруулах боломжтой болсон.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү газар нутаг нь хөрс газарзүйн мужлалын хувьд Төв Азийн их мужийн Хангай Хэнтийн өмнөдийн дэд мужид хамаарна. Энд хуурай хээрийн тал, хотгор, жижиг цав толгодын нунтаг карбонатлаг хар хүрэн, уугуул хэлбэрийн чулуурхаг нимгэн ба гүйцэд хөгжилтэй хөрс зонхилно.

Харин шохойн чулууны орд нь тектоникийн хөдөлгөөнөөр уулын цул газрын гадаргад ил гарч бутран тархсаны улмаас гүвээ толгод хэлбэртэй гадаргуу болон тогтжээ. Энэ гадаргуугийн чулуулгийн зай, завсар элэгдэл, хуримтлалаар дүүрч өнгөн хөрс бүрдэх нөхцөл болсон байна. Иймээс ордын дээр бүрэлдэн тогтсон хөрсний зузаан янз бүр зарим хэсэгт 1.5м байхад зарим газартаа 5 м хүртэл зузаантай байдаг байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүнээрээ шавранцар бөгөөд хүчиллэг талст чулуулаг дээрх уулын хүрэн хөрсөнд тооцогдоно.

Жалга хөндийн хэсгээр элэгдэл хуримтлалын шинжтэй, усны зөөгдлөөр үүссэн хөрсөн бүрхэвч зонхилно. Уурхайн ухсан хэсгээс хөрсний тогтцыг үзэхэд эндэхийн хөрсний шилжилт нь тод ялгаран харагдах бөгөөд ерөнхийдөө гурван үе давхаргаас тогтсон байна. Үүний дээд хэсэг нь тоосорхог, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, азот, фосфорын хангамжаар муу, калийн хангамж дунд зэрэг, хөрсний уусмалын орчин саармаг, ялзмагийн хэмжээ багавтар давсжаагүй, ургамлын үндсээр баялаг байхад дундах үе нь тоосорхог шавар механик бүрэлдэхүүнтэй, маш их давсажсан, сульфатын ион зонхилсон, хөрсний уусмалын орчин сул шүлтлэг цайвар бор өнгийн хөрс байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах байлаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

Цемент, шохой үйлдвэрлэх технологийн үе шатуудад орчинд утаа, тоосжилт үүсгэснээр орчны хуурайшилт үүсгэх сөрөг нөлөөлөлтэй.

Иймд бид Сэлэнгэ аймгийн Цаг уур орчны шинжилгээний газартай гэрээ байгуулан агаар, хөрсний шинжилгээг тогтмол хийлгэж ирсэн ба шинжилгээний дүнгээр илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

“Цемент шохой” ХХК нь 2023 онд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн болно.

Үүнд:

- Агаарын чанар: 2023 оны 5, 10 саруудад /2 удаа / Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний газраас 2 хүний бүрэлдэхүүнтэй лаборатори шинэжээч үйлдвэрийн хашаан дотроос гэрээнд заагдсан 5 цэгээс агаарын шинжилгээний дээжийг авч тухай бүр хариуг ирүүлсэн болно. Шинжилгээгээр азотын давхар исэл, хүхэрлэг хий MNS 4585:2016 стандартад заагдсан хүлцэх агууламжаас даваагүй. Харин тээрэм цех, бутлуурын хэсгийн орчмоос авсан нийт тоос 1.22-1.70 дахин давсан. Нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/ 1.1 дахин, том ширхэглэгт тоосонцор 3.8 дахин давсан дүгнэлт гарсан.
- Ус: Үйлдвэрийн шугамын усыг 2023 оны 5 болон 10-р саруудад буюу нийт 2 удаа шинжилгээнд хамруулсан ба Сэлэнгэ аймгийн Ус Цаг Уур Орчны шинжилгээний албаны Байгаль орчны лабораторид шинжлүүлээ. Уг шинжилгээний дүнд усны химийн чанарын ихэнх үзүүлэлтүүд нь ундны ус болон ахуйн зориулалтаар хэрэглэх, усны чанар аюулгүй байдлын хяналт шинжилгээний MNS 900:2018 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байсан.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/160 тушаалаар томилогдсон идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй бохирдлыг судлах, байгаль орчны багц хуулийн хэрэгжилтэд газар дээр нь ажиллах дүн шинжилгээ хийх үүрэг бүхий “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв”-ийн УТҮГ-ын захирал Х.Ганбаатар ахалсан ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэргэдэх Хяналтын төв лабораторид ундны ус болон гүний худагт

MNS 900:2018, MNS ISO 11885:2011 /ICP/ стандартын дагуу дүн шинжилгээ хийлгэхэд агрохимийн үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй хэвийн гэж дүгнэлт гарсан.

- Хөрсний чанар: Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хяналт шинжилгээг 2023 оны 5 болон 10-р саруудад Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний газрын Байгаль орчны лабораторитой байгуулсан гэрээний дагуу 2 удаа явуулсан. Үйлдвэрийн хашаан дотроос 3, 2 цэгт хөрсний дээжийн хяналтын цэгээс MNS 3297:2019 агрохимийн үзүүлэлт, MNS 6838:2020 нефтийн бүтээгдэхүүн, MNS 5850:2019 хүнд металл зэрэг стандартын дагуу хөрсний дээж авч шинжлүүлэхэд үзүүлэлтүүд стандартаас даваагүй хэвийн байв.

Мөн "Байгаль орчны судалгаа шинжилгээний төв"-ийн судалгааны ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдөр үйлдвэрийн хашаан дотор болон Хөтөл 1, 2 ил уурхай, хогны отвал орчмын 15 цэгээс дээж авч итгэмжлэгдсэн "Хан лаб" ХХК-аар шинжлүүлэхэд MNS 5850:2019 хөрсний агрохимийн үзүүлэлт, хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металл, MNS 3297:2019 хөрсний эрүүл ахуйн үнэлгээ зэрэг стандартаас даваагүй байв.

Бид хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.


Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр ба шохойн чулууны ордод сөрөг нөлөөллийн үйл ажиллагааг хамтад нь дараах байдлаар гүйцэтгэсэн болно.



Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тухайн районд ногоон байгууламжийг сайжруулах, нөхөн сэргээлт болон орчны усалгаа, тохижилтын ажлыг жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилладаг.

“Цемент шохой” ХХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 49,508,100 (дөчин есөн сая таван зуун найман мянга нэг зуу) төгрөг төсөвлөсөн байна.

“Цемент шохой” ХХК-ний техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг



“Цемент шохой” ХХК-ний биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг



2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

(Эхний 10 сарын байдлаар)

Уулын ажил	Хэмжих нэгж	НИЙТ		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувь/
Өрөмдлөг	уртааш метр	5,987	6,577	110%
Хөрс хуулалт	м3	114,462	91,100	80%
Шохойн чулуу олборлолт	тонн	58,102	81,385	140%

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Агаарын чанар

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Үйлдвэрлэлтийн явцад агаарыг бохирдуулах сөрөг нөлөөлөл	Агаарын чанарын дотоод хяналтыг тогтмол явуулах /ОХШХ-өөс харах/	Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвтэй байгуулсан гэрээний дагуу 2023 оны 5, 10-р саруудад 2 удаа шинжилгээ хийлгүүлэхэд 5-р сард нийт тоосны хэмжээ MNS 4585:2016 стандартаас 1,1 дахин их, 10-р сард бутлуур орчмоос авсан нийт тоос 1,22-1,7 дахин их, том ширхэглэгт тоос буюу PM10 хүлцэх агууламжаасаа 3,8 дахин их тоостой гарсан. /Хавсралт №1/
2	Агаарын бохирдлоос үүсэлтэй ажилчдад учрах сөрөг нөлөө	Үйлдвэрийн бүх ажлын байруудын эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих	Тоосжилт ихтэй ажлын байруудад “Юнител” ХХК-тай хамтран Агаарын чанар шалгах хяналтын багаж суурилуулж хяналтыг тогтмол хийж байна. /Хавсралт №2/
3	Агаарын тоосжилтын сөрөг нөлөөлөл	Технологийн үйл ажиллагаа явагдах замуудад усалгааг тогтмол хийх	Усалгааг батлагдсан графикийн дагуу технологийн зам талбайг 7 хоногийн 7 өдөр өглөө 08-20 цаг хүртэл тогтмол усалж, зам талбайд үүсэх тоосжилтыг бууруулж ажилласан.

4	<p>Үйлдвэрлэлийн явцад тоног төхөөрөмжөөс гарч буй утааны нөлөө</p>	<p>Тоног төхөөрөмжийн дотоод шаталтат хөдөлгүүр болон халаалтын том, жижиг оврын зуух, цахилгаан үүсгүүрийн хаягдал утаанд хорт хий, тоос багасгах шүүлтүүр тавих, утааны шүүлтүүрийг тогтмол солих</p>	<p>Цементийн үйлдвэр, Чулуунцарын үйлдвэрийн цахилгаан фильтерийн тоосонцор шүүх уутнуудыг нормын дагуу сольж ажиллаж байна. /Хавсралт №3/</p>
5	<p>Хаягдал нунтаг шохойны агаарт дэгдээж буй нарийн тоосонцрын сөрөг нөлөө</p>	<p>Шохойн үйлдвэрийн гаднах хаягдал чулуулгийн овоолгын үлдэгдлийг үйлдвэрлэлд ашиглаж орчныг цэвэрлэх</p>	<p>Олон жилийн үйлдвэрлэлийн явцад дутуу шаталтаас үүссэн хаягдал нунтаг шохой (Козель)-г технологийн орц, норм, картын дагуу үйлдвэрлэлд дахин ашиглаж, байгаль орчинд шууд хаягдах хаягдлыг бууруулж ажиллаж байна.</p>
6	<p>Шохой үйлдвэрлэлтийн явцад гарч буй сөрөг нөлөө</p>	<p>Шохойн чулуу шатаах явцад гарч буй хий, тоос тоосонцор агаарт дэгдсэнээр учирч болох аюул, эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд ямар замаар хамгаалах, арилгах талаар ажилчдыг сургалтад хамруулж, мэдлэгийг дээшлүүлэх</p>	<p>2023 оны 01-р сарын 03-ны өдрийн А/01 тушаалаар "Нийт ажилчдын сургалт"-ыг 1-2-р саруудад зохион байгуулсан. Мөн Хог хаягдлын тухай хуулийн 10.2.16 аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх үүргийн дагуу байгаль орчны сургалтад агаарын бохирдлын эх үүсвэр, түүнийг бууруулах, хог хаягдал ангилан ялгах чиглэлээр ажилтнуудад мэдлэг олгох чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулсан. /Хавсралт №4/</p>

7	Орчны тоосжилтоос үүсч буй сөрөг нөлөөлөл	Салхи, шуургатай үед тоос шороо зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа зам, талбай, овоолгуудыг услах	Чийгшүүлэх шаардлагатай зам талбайг усалгааны графикийн дагуу тогтмол усалдаг.
8	Техник болон тээврийн хэрэгслүүдээс гарч буй сөрөг нөлөө	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношилогоонд хамруулж, тээврийн хэрэгслээс ялгарах утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	2023 оны үзлэг оношилогоонд нийт тээврийн хэрэгслүүдийг хамруулж, засвар хийх талбайг хатуу хучилттай болгож засвар үйлчилгээг тогтмол хийж байна.
9	Технологийн ажил явагдаж байх хугацаанд үүсэж байгаа нөлөөлөл	Тэсэлгээ хийх, хөрс хуулах үеийн байршлуудын салхи ихтэй үеүдэд сул шороо ихтэй зам талбайн гадаргыг чийгшүүлж байх	Чийгшүүлэх шаардлагатай хэсгүүдэд усалгааг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Гадаргын ба газрын доорх усны нөөц

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Газрын доорх усны нөөцөөс үүсэх хомсдол	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	“Усны газар” МУЗГХА-аар 2023.06.13-ны өдөр 123 тоот ус ашиглах дүгнэлт, 2023.07.05-ны өдөр Орхон чулуут сав газрын захиргаанаас А/18 тоот ус ашиглах зөвшөөрлийн тушаал, 2023.07.31-ны өдөр 06 тоот ус ашиглах гэрээ, 2023.08.25-ны өдөр “Гавшгай ус” ОНӨААТҮГ-тай цэвэр усаар хангах болон бохир ус татам зайлуулах БГ/23/01 тоот гэрээг 1 жилийн хугацаатай байгуулав. /Хавсралт №5/

2	Ундны усанд гарах нөлөөлөл	Усны эх үүсвэрүүдийн худгуудаас жилд 2 удаа дээж авч, ундны усны агрохимийн бүрэн шинжилгээ хийх, бохирдол тодорхойлох, ахуйн болон үйлдвэрээс гарах бохир уснаас дээж авах ажлыг зохион байгуулах	2023 онд 3 удаа Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн лаборатори болон БОАЖЯ-ны харьяа БОСШТөвийн итгэмжлэгдсэн Хяналтын төв лабораториор ундны болон ахуйн усыг шинжлүүлж шинжилгээ хийлгэсэн. /Хавсралт №6/
3	Үйлдвэрийн хэмжээнд унданд хэрэглэж буй усны сөрөг нөлөө	Шинжилгээний үр дүнг ундны болон цэвэр, бохир усны стандарттай харьцуулж, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолд хариу арга хэмжээ авч байх	Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн лабораториор ундны болон ахуйн усыг шинжлүүлж шинжилгээ хийлгэсэн. Гал тогооны ундны усны дээжээс үзэхэд рН-7.8 шүлтлэг, хатуулаг 26.1 буюу стандартаасаа 3 дахин өндөр хатуулагтай байна. Хатуулаг ус нь булингартай цагаан тунадастай байдаг. Үүнийг арилгахын тулд ус зөөлрүүлэгч шүүгч тавих шаардлагатай юм. /Хавсралт №7/
4	Гүний усны ундаргад үүсэж буй нөлөө	Гүний усны нөөц, чанарт байнгын хяналт тавьж, түвшний хэмжилт, дээжлэлт хийж, баримтжуулах	Гүний усны ундаргыг баталгаатай тоолуурын заалтыг үндэслэн хэмжилт хийдэг. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга хот байгуулалтын сайдын А-230/127 тоот тушаалын хавсралт Усан сан бүхий газар усны эх үүсвэрийн болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дагуу заалтын гүний худгийн эргэн тойронд 50м доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтоосон. /Хавсралт №8/

5	Хатуу, шингэн хаягдлаас үүдэлтэй сөрөг нөлөө	Уурхайн ойр орчим хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх	Уурхай орчим ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар сургалтыг тогтмол орж, зөвлөгөө зөвлөмж өгдөг. 7 хоног бүр үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг албан шаардахаар өгч, тухайн зөрчлүүдийг арилгуулан ажилладаг. Мөн Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн лабораториор нефтийн бүтээгдэхүүн шинжлүүлэхэд стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй гараагүй болно. /Хавсралт №9/
---	----------------------------------------------	----------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Хөрсөн бүрхэвч

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Үйлдвэрийн бүс нутгийн хөрсөнд нөлөөлж буй сөрөг нөлөө	Хөрсөнд агуулагдах хүнд хортой элементийн агууламж, агрохимийн үзүүлэлтүүд, Нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох	Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн шинжилгээгээр 05, 10-р саруудад, БОСШТөвийн дэргэдэх “Хан лаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораториор 08-р сард уурхайн орчны хөрснөөс агрохимийн үзүүлэлт, хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт, хүнд металл зэргээр хөрсний дээж авч шинжилгээ хийлээ. /Хавсралт №10/
2	Хөрсний элэгдэл, эвдрэх сөрөг нөлөө	Технологийн үйл ажиллагаа явагдах замууд ба нүүрс буулгах талбай, бетонон хучилтгүй хэсэг талбайд усалгааг тогтмол хийх	Усалгааг тогтмол хийж тоосжилтыг бууруулж ажилласан.

3	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх сөрөг нөлөө	Шатах, тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, шатах тослох материал санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс, хайрган хучилт хийж өгч, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хийж байрлуулах	Шатах, тослох материал хадгалах, засварын талбайг хатуу хучилттай талбайд байрлуулсан. Галын буланд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.
4	Орчны эрүүл ахуй алдагдах сөрөг нөлөө	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг агаар, ус чийг, салхинаас бүрэн хамгаалах түр хураан хадгалах байр сав байгуулах, тэмдэгжүүлэх, ухуулах самбар байрлуулах, тогтмол хугацаанд хогийн нэгдсэн цэгт тээвэрлэж хаях	Ахуйн хог хаягдлыг түр хураан хадгалах саванд цуглуулдаг ба сумын Хот тохижилтын газартай байгуулсан гэрээний дагуу хогийн цэгт тээвэрлүүлдэг. /Хавсралт №11/
5	Хөрс талхлагдах сөрөг нөлөө	Авто зогсоолыг болон шохойн чулууны уурхайн талбайн дотор ба гадна орчны авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэгжүүлэлт хийх	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээтэй.

6	Хөрсний бохирдол үүсэх сөрөг нөлөө	Уурхай дээрх засварын төвийн хаягдал тосыг автобаазын хатуу хучилттай талбайтай нэгтгэх, төмрийн хаягдлыг цэгцлэх	Уурхай дээрх ажилласан тосыг тухайн цэг дээр түр төвлөрүүлж байгаад, Хуурай аргын үйлдвэрийн хатуу хучилттай ажилласан тос хадгалах байранд зөөвөрлөн хадгалж байна. /Хавсралт №12/
7	Хөрсний физик шинж чанар алдагдах сөрөг нөлөө	Техникийн засвар, үйлчилгээг авто гарш дотор тогтмол явуулж байх	Техникийн засвар үйлчилгээг зориулалтын хатуу хучилттай авто гарш дотор явуулдаг.

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2023 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар үйлдвэрлэлийн хаягдал хуримтлуулсан 2,5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ч 6 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлээ.	MNS 5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн дутуу шатсан козель хуримтлуулсан 3,3 га талбайд олон наст согооврын үрээр зүлэгжүүлэлт хийсэн.	MNS 5918:2008

5.1 ТЕХНОЛОГИЙН ХАЯГДАЛ ХУРИМТЛАГДСАН ТАЛБАЙ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

“Цемент шохой” ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан технологийн хаягдал хуримтлагдсан 2,5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 7-9 саруудад ГУУХэлтэстэй хамтран



40923м³ козелийг Howo маркийн өөрөө буулгагчаар 2154 рейс зөөж, R800 экскаватороор ачиж, TW220 бульдозероор нийт 6 га талбайг түрж тэгшлэх ажлыг 55,580,940 төгрөг өөр хийж гүйцэтгэлээ.

5.2 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

2023 оны биологийн нөхөн сэргээлтэд тусгагдсан төлөвлөгөөний дагуу технологийн хаягдал хуримтлуулсан 3,5 га талбайд олон жилийн турш хуримтлагдсан, дахин ашиглагдахгүй технологийн хаягдлуудыг үйлдвэрлэлийн түр хадгалах отвалруу зөөж талбайг чөлөөлөх байдлаар техникийн нөхөн сэргээлт хийсний дараа үржил шимт хөрсөөр хучин тэгшилж, биологийн нөхөн сэргээлт хийх талбайг бэлдэж өвөлжүүлсэн.

2023 оны шимт хөрс буулгаж дууссаны дараа талбайг тэгшилж, 6 дугаар сарын 16-нд зүлэгжүүлэлтийн ажлыг MNS 6260:2020 стандартын дагуу 1м2 талбайд 30гр үрийг МТБ80-маркийн трактор болон ОМИЧК-2,1 силк үрлэгчээр зүлэгжүүлэлтийг хийж ажлыг 100% гүйцэтгэлтэй 19,015,150 төгрөгийн зарцуулалт хийж ажилласан.



5.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн БОАЖГазраас 2023 оны 02 сарын 02-ний өдрийн 64 тоот албан бичиг ирүүлсэн. Уг албан тоотод Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй

49 24 47.57 107 22 34.98

49 24 38.75 107 22 25.54

49 24 41.18 107 22 18.50

49 24 51.65 107 22 28.40 солбицол бүхий эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 6 га талбайд холбогдох журам, стандартын дагуу талбайн нөхөн сэргээлтийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз

байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах саналыг тусгасан.

2023 оны БОМТөлөвлөгөөний “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд” бичил уурхайн улмаас эвдрэлд орсон газрын техникийн нөхөн сэргээлтийг MNS 17.5.1.19-92, MNS 5917:2008 стандартын дагуу “Хишигтэн Залуус” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн. Тус арга хэмжээний ажилд 190,382,434 төгрөг зарцуулсан.

Техникийн нөхөн сэргээлт хийгдэхээс өмнөх талбай



Техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан талбай



5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйлийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан.

Гэвч Хөтөлийн “Цемент Шохой” ХХК-ний эзэмшиж буй газарт малчид болон орон нутгийн иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээтэй намаржаа, өвөлжөө, хаваржааны байршил байхгүй юм. Тиймээс нөхөн олговрын асуудал байна.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын “Соёлын Өвийг Хамгаалах Тухай” хуулийн 6-р бүлгийн 17-р зүйлийн 10-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна” гэж заасны дагуу ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн археологийн хайгуул судалгааны баг Хөтөлийн “Цемент- Шохой” ТӨХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутагт орших “Хөтөл- 2” нэртэй ашигт малтмал ашиглалтын 15249А тоот тусгай зөвшөөрөлтэй, 61.46 га талбайд 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гүйцэтгэж 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 01/180/а.а тоот дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтэд хайгуул судалгааны явцад 1 дурсгал илрүүлсэн ба үүнийг Монголын түүхэн үед холбогдох булш оршуулгын дурсгал хэмээж тус талбайд мэргэжлийн байгууллагаар малтлага судалгаа хийлгэх шаардлагатай хэмээн үзсэн тул ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах АГГ/14/76 тоот гэрээг 2014 оны 7 сарын 31-ний өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу 2014 оны 8 сард Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт орших цемент, шохойн уурхайн хөрс хуулалтын ажилд өртөх магадлалтай 1 дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааны хээрийн ажлыг гүйцэтгэлээ. Тус судалгаанд хамрагдсан дурсгал нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт сумын төвөөс зүүн урд зүгт 4 км зайд буюу уурхайн талбайд байрлаж байлаа. Энэхүү судалгааны туршид уурхайн ашиглалтын явцад өртөж болзошгүй байсан нэг дурсгалыг малтан судалж талбайг чөлөөлсөн болохыг Археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайланд дүгнэсэн байна. Одоог хүртэл түүх, соёлын өв дахин олдоогүй.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Химийн бодисын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөөний тайлан/

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжүүлэх эзэн	Тайлангийн биелэлт
1	Химийн хорт болон аюултай бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад зохих дүрэм, журмын дагуу хадгалж, ашиглаж, устгах үйл ажиллагааг аюулгүй зохион байгуулах	2023 онд	СШЛабораторийн эрхлэгч, ХАБЭА, БОХ	2023 оны 3-р улирлын байдлаар химийн хорт бодисын агуулахын үйл ажиллагааг аюулгүй байдлыг ханган, зохион байгуулан ажиллаж байна.
2	Химийн хорт болон аюултай бодис хадгалах складыг зохих журмын дагуу ашиглаж, тогтмол хараа хяналттай, цоожтой байлгаж, хаалгыг лацдах	Тогтмол	Инженер /Аналитик/, Техникийн менежер, нярав	Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг зохих журмын дагуу хариуцан эзэмшиж хянан ажиллаж байна.
3	Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дээр тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг харуулсан тод, том шошго зэргийг шинэчлэн хадаж байрлуулах	I-р улиралд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Химийн хорт болон аюултай бодисын агуулахад байгаа химийн бодисын нэр хаягийг бүрэн тавьсан болно.
4	Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй	тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Стандартад нийцсэн химийн бодисын агуулахыг ашигладаг болно.

	байдлын нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулах			
5	Ажлын байран дээр ашиглагдаж байгаа химийн бодисуудыг хадгалж буй шүүгээ нь бат бөх болон хэт олон бодис дүүртэл хадгалсан эсэх, тавиур дээрх химийн бодисыг хана болон шаланд сайтар бэхлэгдсэн эсэхийг шалгаж аюулгүй байдлыг хангах	Тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер, инженер /Ээлжийн/	Ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
6	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилладаг ажилтан нарт болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулах	Жилд 2 удаа	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Химийн хорт болон аюултай бодистой харьцан ажилладаг ажилтан нарт 2023 оны 9 сарын 22-нд 88,5% ирцтэйгээр зохион байгуулсан болно.
7	Химийн хорт болон аюултай бодисын зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан, мэдээг Сайхан сумын Засаг даргад жил бүрийн 12-р сарын 15-ны дотор, Сэлэнгэ аймгийн БОАЖГ, БОАЖЯамруу тус тус дараа оны 1-р сард хүргүүлэх	Тухай бүрд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Зарцуулалтын тайланг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.
8	Нэр төрөл, шинж чанар, хэрэглэх заавар тодорхой бус химийн	Тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/,	Химийн бодисын тусгай зөвшөөрөлд тусгагдсан,

	хорт болон аюултай бодисыг эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр ашиглахгүй байх		Техникийн менежер	шинжилгээнд ашиглагддаг химийн бодисуудыг худалдан ашигладаг.
9	Химийн хортой бодисын хуванцар сав, аюултай хог хаягдлыг тухай бүрт гэрээт байгууллагад хүргүүлж, устгуулах	Жилд 1 удаа	“Элемент” ХХК, ХААХэлтэс, СШЛаборатори	2023 оны 04 сарын 06-ний өдөр “Элемент” ХХК-тай химийн хорт болон аюултай бодисын хаягдал тээвэрлэн устгах ажил гүйцэтгэх гэрээг байгуулан 40 жил хуримтлагдсан байсан хугацаа дууссан болон нэр хаяг тодорхойгүй химийн бодисыг устгуулсан болно.
10	Ашиглахгүй болсон химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг зөвшөөрөлтэй газраар, эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй аргаар холбогдох комиссыг байлцуулан устгаж, акт үйлдэх	2023 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер, БОМэргэжилтэн, мэргэжлийн байгууллага	

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Ахуйн	Үйлдвэрлэлийн цех, хэсгүүд, оффис зэргээс гарах хог хаягдалд ялгалт хийж, энгийн хог хаягдлыг ангилан түр хадгалах цэгт байрлуулах	Сайхан сумын Хот тохижилтын газартай байгуулсан гэрээний дагуу 7 хоног бүрийн 5 дахь өдөр сумын хогийн цэг рүү ачуулдаг.
		Хог хаягдлын цэгийг тусгай хашаа бүхий бетондсон талбайд байрлуулах, тохижуулах, хаягжуулах, 7 хоногт 1 удаа ариутгал хийх	Хогийн цэгийг бетондсон талбайд байршуулдаг ба 7 хоног бүр ариутгал халдваргүйтгэл хийдэг.
		Нийт ажилчдад 2017 оны 5-р сарын 12-нд батлагдсан "Хог	2023 оны 1, 2-р сард "Нийт ажилчдын сургалт"-ыг зохион

		хаягдлын тухай хууль"-ийг танилцуулах сургалт зохион байгуулах, аюултай хог хаягдлыг хадгалах тал дээр түлхүү анхаарах, хяналтыг сайжруулах	байгуулсан. Сургалтын хичээлийн агуулгын хүрээнд хог хаягдлын талаар түлхүү тусгаж орсон.
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн технологиос гарсан хаягдлыг үйлдвэрлэлд нэмэлтээр ашиглах, байгальд хаягдах хог хаягдлыг багасгах	Дутуу шатсан хаягдал козелийг хуурай аргын үйлдвэрт нэмэлтээр ашиглаж байна. Дулааны станцын үнсийг цементийн нэмэлтээр ашиглаж, байгальд хаягдах хаягдлыг бууруулж ажиллаж байна.
		Үйлдвэрлэлд дахин ашиглах боломжгүй технологийн хаягдал, цэвэрлэгээний тоос, шороог үйлдвэрлэлийн хог хаягдлын отвол руу тээвэрлэх, үйлдвэрийн орчныг цэвэр байлгах, технологийн сахилга батыг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн технологиос гарч буй хаягдалд хяналт тавин аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг отвальруу зөөвөрлөдөг. /Хавсралт №13/
3	Аюултай	Аюултай хог хаягдлын цэгийг тусгайлан байгуулж, хязгаарлалтын бүс тогтоон уг хаягдлыг битүүмжлэл сайтай саванд хадгалж, таних тэмдэг, анхааруулах санамж байрлуулан, бүртгэл хөтлөн тайлан гаргаж байх.	Цех бүрд аюултай хог хаягдал хадгалах түр цэгийг тусгайлан байгуулан таних тэмдэг тавьсан.
		Авто тээврийн хэрэгслүүдийн ашигласан тосыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоож, аюултай хог хаягдал боловсруулах эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, устгах эрх бүхий "Элемент" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж аюултай хог хаягдлаа устгуулсан. /Хавсралт № 14/
4	Бүртгэл, гэрээ болон бусад	Үйлдвэрийн орчны хог хаягдлыг цэвэрлэх хуваарийг шинэчлэн баталж мөрдүүлэх	Үйлдвэрийн орчны хог хаягдлыг цех нэгжүүд хариуцсан талбайг тогтоон өгч, цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.

	Хог хаягдлыг бүртгэлжүүлж, тайлан мэдээг Сэлэнгэ аймгийн МХГ, БОАЖГ, Сайхан болон Орхон сумын БОХУ байцаагч нарт улирал бүр хүргүүлэх	Улирал бүр үйлдвэрээс гарсан бүх хаягдлын тоо хэмжээг хөтөлж, нэгтгэн Сэлэнгэ аймгийн БОАЖГ, Сайхан болон Орхон сумдын БОХУ байцаагч нарт хүргүүлж ажиллалаа. /Хавсралт № 15/
	Цехүүдийн харъяа талбайн цэвэрлэгээний ажлыг тогтмолжуулах, хяналтын системийн хуваарийг боловсруулж, хяналт тавих	Цех нэгжүүд хувиарт талбайн цэвэрлэгээг тогтмол хийж ажилласан.

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Дээж авах цэг	Цэгийн тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Орчны агаар дахь NO ₂ SO ₂	Шохой, Бутлуур, Чулуунцарын Дамжлаг, Тээрэм, Савлах	5*2	18,500	185,000
2	Цацрагийн үзүүлэлт	Бэлэн бүтээгдэхүүн / цемент, шохой/ Үйлдвэрлэлийн хог хаягдлын отвал орчмын хөрс	3*2	5,000	30,000
3	Тоос PM10	Төмөр замын цехийн 3-н давхарт	1*2	20,000	40,000
4	Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд/ялзмаг,РН,д авсжилт, хөдөлгөөнд азот-NO ₃ -N, фосфор-Р2O5, кали-К2O/, ширхэгийн бүрэлдэхүүн, нягт, эзлэхүүн, жин, ус нэвтрүүлэх чадвар, чийгшил	Дурын 3 байршилд	3*2	42,500	255,000
5	Хөрсний хүнд металлын бохирдол Хар тугалга/Pb/, Хром /Cr/, Цайр/Zn/, Никель /Ni/, Кадми /Cd/, /ГЗХ, БОХЗТЛ/	Лаборатори, Засварын нэгдсэн, хогийн отвал орчим	3*2	36,000	216,000

6	Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох хөрсний бохирдол	Хөтөл- 1, 2 орд	2*2	50,000	200,000
7	Ундны усны хиймийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Усны эх үүсвэрийн худгуудаас дээж авах	2*2	50,000	100,000
8	Бохир усны химийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Ахуйн болон үйлдвэрээс гарсан бохир усыг цэвэрлэсний дараа	1*2	46,000	46,000
Нийт үнэ					1,172,000
					0

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж асан цэгийн нэр	Азотын давхар исэл	Хүхэрлэг хий	Тоос (нийт)			PM10		
				Дундаж	Бага	Их	Дундаж	Бага	Их
Хэмжих нэгж мг/м ³									
1	Төмөр замын цехийн 3 давхарт						0.227	0.001	3.108
2	Шохой	0.019	0.007	0.225	0.148	0.571	-	-	-
3	Бутлуур	0.010	0.004	0.414	0.185	1.125	-	-	-
4	Тээрэм	0.022	0.008	0.846	0.29	4.58	-	-	-
5	Савлах	0.029	0.078	0.283	0.196	1.06	-	-	-
6	Чулуунцар	0.016	0.007	0.227	0.206	0.378	-	-	-
MNS 4585:2016		0.200	0.450	0.500			0.100		

Шинжилгээний дүнгээс үзэхэд Төмөр замын оффис дээр байрлуулсан цэгээс 24 цагийн хэмжилт авахад нарийн ширхэглэгт тоосны хэмжээ MNS4585:2016 стандартаас 3 дахин хэтэрсэн байна. /Шинжилгээний дүн хавсаргав/

УСНЫ ЧАНАР

Стандарт MNS900:2018 (хатуулаг) 7.0
Стандарт MNS900:2018 (pH) 6.5-8.5

Шугамын ус	РН	Ерөнхий хатуулаг, мг-экв/дм ³	Он сар өдөр
Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Цемент шохой ХХК-ийн ажилчдын цайны газар шугамын ус	8,01	11,8	2023 оны 5, 8, 10 сар

Шинжилгээний дүнгээс үзэхэд ундны ус шүлтлэг орчинтой, хатуулаг нь MNS900:2018 стандартаас 1,6 дахин давсан байна.

ХӨРСНИЙ ЧАНАР

Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд /хэмжих нэгж/ гр/кг		
	РН	Сульфат	Нитрат
Цементийн үйлдвэр	7.21	92.8	16.6
Хөтөл-1 ил уурхай	7.19	53.8	8.7
Чулуунцарын үйлдвэр	7.74	58.6	14.7
MNS 3297:2019	6-9	160.0	130.0

Дээрх цэгүүдээс 0-5 см-н гүнээс авсан хөрсний дээжинд агрохимийн шинжилгээ хийж, MNS 3297:2019 стандарттай харьцуулан хөрсний ариун цэврийн байдлыг тоон үзүүлэлтээр үнэлж үзэхэд цэвэр дүгнэгдсэн. /Шинжилгээний дүнг хавсаргав/

10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

№	Албан шаардлагаар ирүүлсэн зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг зохих байгууллагуудаар батлуулах	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тушаалаар менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. /Хавсралт №16/	100%
2	Техникийн нөхөн сэргээлт хийх, бололцоотой болон хийгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэхээр төлөвлөж, санхүүжүүлэх	2023 оны БОМТ-ний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.	100%
3	Газар ашиглах гэрээг байгуулах, урьд жилийн төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төлөврүүлэх	1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт 112.860.669 төгрөг төлсөн.	100%

	2. Газар ашигласны төлбөр нийт 12.487.188 төгрөг төлсөн	
	3. Ус ашигласан төлбөр 19,364,397.33 илүү төлөлттэй байна.	
	4. Агаарын бохирдлын төлбөр 19.179.593 төгрөг төлсөн.	100%

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл
1	“Хөтөл 1, 2 ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ”-ийн нэмэлт тодотгол	<p>Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник эдийн засгийн үндэслэлийг тодотгох үүргийг хүлээнэ.</p> <p>Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумдын нутагт орших “Хөтөл-1, 2 ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол-1” 2022 онд “Роял майнинг” ХХК-аар гүйцэтгүүлж 2023 оны 6-р сард ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулан АМГТГ-т хүлээлгэн өгч ТЭЗҮ-ний нэмэлт тодотгол батлагдсан.</p>
2	Хэвтээ эргэх зуухтай шинэ “Шохойн үйлдвэр” ТЭЗҮ хийлгэх	<p>Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-дугаар зүйлд заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник эдийн засгийн үндэслэлийг шинээр боловсруулах үүргийг хүлээнэ.</p> <p>2023 онд хэвтээ эргэх зуухтай шинэ “Шохойн үйлдвэр” барих төслийн ТЭЗҮ-ийг 2023 оны 6-р сарын 28 өдөр ЭБМЗ-ийн Т/23-09-08 тоот дүгнэлт, 8-р сарын 17 өдөр “Цемент шохой” ХХК-ийн МУ-012219 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хөтөл-1” ордыг ил аргаар ашиглах, эргэх зуухаар шохой үйлдвэрлэх ТЭЗҮ-ийг</p>

		хүлээн авах тухай Ашигт малтмал газрын тосны газрын даргын Т/80 тоот тушаалаар бүртгэж “Булжих минерал майнинг” ХХК-аар гүйцэтгүүлэн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.
3	Байгаль орчны аудит	<p>БОАЖ-ын сайдын 2019 оны 12 –р сарын 25-ны өдрийн А/809 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батласан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”-д заасны дагуу:</p> <p>2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 3 дугаар сарын 14-ны өдөр хүртэл “Өртөөлөн” ХХК-иар 2021-2022 оны үйл ажиллагаанд байгаль орчны аудитын хяналт шалгалт хийлгэж тайлан болон дүгнэлт, зөвлөмжийг Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын Байгаль орчин аялал жуулчлалын газар болон Сайхан сумын ЗДТГазар, Орхон сумын ЗДТГазарт эх хувиар хүргүүлсэн. Байгаль орчны аудитын нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийн нийцлийн нэгдсэн дүнгээр 128 шалгуур үзүүлэлтээс 87.5% нь нийцэл, 3.9% нь үл нийцэл, 8.6% нь дүгнэх боломжгүй байна.</p>
4	“Хөтөл 1, 2 ордыг ил аргаар ашиглах” БОННҮнэлгээний нэмэлт тодотгол	<p>Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.12 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйл заалтыг үндэслэн:</p> <p>2023 оны 01-р сарын 06-ний өдөр тендерийн баримт бичиг, тендэрт оролцогчид зориулан гаргасан ажлын даалгавар нөхцөл, шаардлагын дагуу Хөтөл-1, 2 ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий “Эко экспресс” ХХК-ийг сонгон шалгаруулсан. Тус байгууллагатай хуулийн хүрээнд ЦШ/202210360 дугаартай гэрээ байгуулан 2023.08.16-ний өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас №12/4327 дугаартай Ерөнхий үнэлгээний</p>

		дүгнэлт гарч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газраас 09-р сарын 19-ний өдөр ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гарч БОАЖ-ын яаманд тайлангаа илгээсэн.
5	Хэвтээ эргэх зуухтай шинэ “Шохойн үйлдвэр”-ийн БОННҮнэлгээ	Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.12 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйл заалтыг үндэслэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.2 зааснаар хуульд заасан журмын дагуу тус байгууллагатай 2023 оны 02-р сарын 24-ний өдөр “Хэвтээ зуухтай, шохойн үйлдвэр”-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж төслийн талбайд төлөв байдлын судалгааг гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуучлалын яамнаас 2023 оны 10-р сарын 05-ний өдөр №12/5353 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан.
6	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх болон аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах /сөрөг нөлөөллийг бууруулах хэсэгт дурдсан сэдвүүдийг сургалтын агуулгад багтаах/	Байгаль орчны сургалтад агаарын бохирдлын эх үүсвэр, түүнийг бууруулах чиглэлээр ажилтнуудад мэдлэг олгосон.
7	Байгаль орчныг хамгаалах асуудлаар хийгдсэн ажлын тайлангаа тогтоосон хугацаанд Сэлэнгэ аймгийн МХГ, БОАЖГ, Сайхан, Орхон сумын БОХУ байцаагчдад тайлагнах	Улирал бүр БОМТөлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргэж ажилласан.
8	Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Дүгнэлт, гаргуулж, зөвшөөрөл авч, цэвэр усаар хангагч бохир ус татан зайлуулах гэрээ хийсэн. /Хавсралт № 29/

9	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах	Сайхан болон Орхон сумтай хамтран ажиллах “Нийгмийн хариуцлагийн гэрээ”-г байгуулан гэрээний дагуу тус тус ажиллуудыг хийж гүйцэтгэсэн. /Хавсралт № 18/
10	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын багаж хэрэгслээр хангах	Галын багаж хэрэгсэл 100% хангагдсан.
11	Ажлын байран дахь анхан шатны тусламжийн хэрэгслийг сэлбэх	Онцгой дэглэмийн үед ажлын байран дахь анхан шатны тусламжийн хэрэгслийг 100% хангасан.
12	Ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал аюулгүй байдлыг хангаж ажиллах	Техник тоног төхөөрөмжид сар бүр эрсдлийн үнэлгээ, 2-р шатны үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажилладаг.
13	Газар, ус ашигласны болон бусад төлбөрийг холбогдох хууль эрхийн актанд заасны дагуу тухай бүр төсвийн дансанд төвлөрүүлэх	Газар, ус, ашигт малтмал ашигласны төлбөрийг холбогдох дансанд төвлөрүүлсэн.
14	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сурталчилгааны самбар хийж байршуулах	Хог хаягдлаа тогтоосон цэгт хаяж хагжуулалтыг жил бүр сэргээдэг.
15	Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа болгож, 2023 онд байгаль орчныг хамгаалахад төлөвлөсөн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгийг БОАЖЯамны дансанд төвлөрүүлэх	Байгаль орчныг хамгаалахад төлөвлөсөн зардлын 50%-тай тэмцэх 6,255,000 төгрөгийг тусгай дансанд байрлуулсан. /Хавсралт № 19/

12. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН ХҮРЭЭНД

“Цемент шохой” ХХК-ний 40 жилийн ойг тохиолдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд үндэсний өв соёлоо дээдлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Хөтөл хотод жишиг болохуйц сур харвааны талбай 64,585,000 төгрөг, шагайн харвааны талбай 59,389,600 төгрөгийн төсөвтэй хөрөнгө оруулалт, хүн хүч, техник хэрэгслээр бүтээн байгуулалтыг Сайхан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.

Шагайн харвааны талбай:



Сур харвааны талбай:



2023 оны 6 сарын 26-ны өдөр Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглахтай холбоотой Орхон сумын засаг даргатай хамтран ажиллах ХАГ/23-01 тоот гэрээг үндэслэн Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай 2-р багт 42-р Точканы замын бүтээн байгуулалтын хөрс тээврийн ажил 2023 оны 07 сарын 26 өдрөөс 9 сарын 5 өдөр хүртэл хүнд даацын автомашин болон LG-180




Автогрейдер, лодертой эхэлсэн. Энэхүү бүтээн байгуулалт нь 2.2 км урттай зам сайжруулах ажилд 45,009,755 төгрөгийн зарцуулалт гаргасан.

- 2023 оны нийгмийн хариуцлагын хүрээнд Орхон сумын "Тахиан байр"-ны хуучин суурийг нураан 864 мв.куб шороог зөөж, тээвэрлэн үерийн усанд идэгдсэн байсан газар /жалга/-ыг дарж, тэгшилэхэд 4,442,784 төгрөгийн зардал гарлаа.



- Бүх нийтийн цэвэрлэгээ 2023 оны 4-р сарын 5-ны өдөр Сайхан сумын Засаг даргын А/89 тоот захирамжийн дагуу “Бүх нийтийн цэвэрлэгээ” урианд нэгдэж Эрдэнэтийн автозамын ар тал, овоот хорооллын урд хэсгээс зүүн тийш Орхон хүнсний дэлгүүрийн ар тал хүртэл, овоот хорооллын зүүн талаас Дөмбөн хорооллын зүүн талын нүүр хүртэлх хуваарьт талбайг 4-р сарын 7-ны өдөр 250 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж орчны хог хаягдал болон ногоон байгууламжийг цэвэрлэн 3 рейс хог хаягдлыг норд машинаар зөөвөрлөн төв хогийн цэгт хаяж цэвэрлэсэн талбайг байгаль орчны улсын байцаагчид хүлээлгэн өгсөн.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цемент шохой” ХХК нь нэг тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5 жилийн хугацаанд жил бүр 200.000.000 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

I. Эхний ээлжийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл 1-р багт байрлах хүүхдийн паркийн 1.5 га талбайг тохижуулж ногоон төгөл бий болгохоор 150.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлаж Дархан-Уул аймагт байрлах “Өгөөж Ирээдүй” ХХК шалгарч 4.5 га талбайд ландшафт зураг төсөл боловсруулан 1-р ээлжинд 1.5 га талбайг төлөвлөлтийн дагуу усалгааны шугам хоолой татаж нарс-100ш, гацуур-50ш, буйлс-100ш, гүйлс-100ш, шинэс-100ш, агч-400ш, шар хуайс-1000ш хайлаас-



1000ш нийт 2850 ширхэг мод, суулгац тарьж ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

II. Сэлэнгэ аймгийн Орхон сумтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсанаар нийгмийн хариуцлагын хүрээнд үхрийн нүд-1400ш, монос-200ш, хөх далан хальс-1200ш гэсэн 3 төрлийн 50,000,000 төгрөгийн өртөгтэй 3000ш суулгацыг Орхон сумын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад өглөө. Орхон сумын иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь газар тариалан байдаг ба жимсний мод тарьж, ургуулснаар өрхийн амьжиргаанд дэм болох зорилгоор мод бут хэрхэн арчилж тарих талаар зөвлөмж бэлтгэж суулгацын хамт өгсөн.



13. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

<p>БО-ыг хамгаалах үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид оролцогч талууд</p>	<p>Гүйцэтгэл</p>
<p>Сайхан сумын 1-р багийн иргэд</p>	<p>2023 оны 9-р сарын 06-нд Сайхан сумын ЗДТГ-тай хамтран Хөтөл 1-р багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулан холбогдох судалгаа, мэдээ мэдээлэл болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа ажлын явцын мэдээллийг хүргэн ажилласан.</p>
<p>Орхон сумын 2-р багийн иргэд</p>	<p>2023 оны 9-р сарын 06-нд Орхон сумын ЗДТГ-тай хамтран Бэлэндалай 2-р багт 12 цагт багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж “Цемент шохой” ХХК-ний үйл ажиллагааны тайлан болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн талаар мэдээ мэдээллийг багийн иргэд болон аж ахуй нэгжид хүргэсэн.</p>

2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХЭД
ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ

№	Төлөвлөгөө, бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал, төг
1	Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга	-
2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12,028,300
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	74,596,090
4	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	190,382,434
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,050,000
8	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2,005,000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	4,599,740
10	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	1,934,271,39
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	6,255,000
12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	400,000
НИЙТ		485,743,703

ДҮГНЭЛТ

“Цемент шохой” ХХКомпани нь 2023 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр төлөвлөсөн ажлуудаа “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”, “АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ” болон “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”-ийн дагуу **66** төрлийн ажлыг гүйцэтгэхдээ **486,188,163** төгрөг зарцуулсан.

1. Уулын ажлын гүйцэтгэл

Уулын ажил	Хэмжих нэгж	НИЙТ		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувь/
Өрөмдлөг	уртааш метр	5,987	6,577	110%
Хөрс хуулалт	м3	114,462	91,100	80%
Шохойн чулуу олборлолт	тонн	58,102	81,385	140%

2. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - Үйлдвэрийн бүсийн агаарын чанарт 5 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
 - Гадаргын болон газрын доорх усны чанарт 6 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
 - Хөрсөн бүрхэвчид 4 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
 - Ургамал, амьтны судалгаа 4 ажил төлөвлөж тус тус 100% хийж гүйцэтгэсэн.
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - 2 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэлтэй.
4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - 1 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэлтэй.
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсээгүй.
6. Түүх соёлын дурсгалт өв шинээр олдоогүй.
7. Осол, эрсдэл, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - 10 ажил төлөвлөж хийж 100%-тай гүйцэтгэсэн.
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - 5 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэсэн.
9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 11 ажил төлөвлөж, Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвтэй байгуулсан гэрээний дагуу Агаар, ус, хөрсний шинжилгээг тус тус 2 удаагийн давтамжтай хийлгэсэн. Гүйцэтгэл-100%.
10. 2023 онд Аймаг нийслэлийн Засаг Даргын тамгын газраас компанид шаардлага ирээгүй байна. Иймд Сэлэнгэ аймгийн МХГ-ын зөвлөмжийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан. Гүйцэтгэл-100%
11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл:
 - 12 ажил төлөвлөж 100%-тай гүйцэтгэсэн.

- Байгаль орчны хуулийн дагуу Хөтөл-1,2 ордын БОННУ-ний нэмэлт тодотгол, Хэвтээ зуухтай Шохойн үйлдвэрийн БОННУ, Байгаль орчны аудитын ажлуудыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүллээ.
- 2023 оны 10 сарын 20-ний байдлаар улсын төсөвт ус, газар, Ашигт малтмал ашигласны 272,115,227 төгрөгийн татвар, төлбөрийг төлөөд байна.
- 2023 онд Байгаль орчныг хамгаалах зардалд нийт **485,743,703** төгрөг зарцуулж ажилласан.


2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ-д тусгагдсаны дагуу амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

ХАВСРАЛТ

Хувьдуг - 1

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2023 /A74-79

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Сорилтын арга, аргачлал

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт

Шинжилгээ хийж дууссан огноо

"Хөтөл Цемент Шохой" ТӨХК

Сайхан сум

БОШЛ-ийн инженер С.Цэнджав

6, Агаарын дээж

2023 - 10 - 12

MNS17.2.5.12:88, MNS17.2.511:88, MNS4048-88

хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос

2023 - 10 - 16

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м3													
		Азотын давхар исэл (NO2)	Хүхэрлэг хий (SO2)	Тоос (нийт)			Том ширхэглэгт тоосонцор (PM10)			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)					
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их			
1	Шохойн цех	0.019	0.009	0.316	0.217	0.739									
2	Бутлуурын цех	0.010	0.005	0.610	0.281	1.21									
3	Тээрэмийн цех	0.017	0.006	0.851	0.301	2.35									
4	Савлах цех	0.014	0.007	0.289	0.224	0.937									
5	Чулуунцарын цех	0.012	0.008	0.280	0.242	0.541									
6	Төмөр зам	-	-	-	-	-	0.377	0.000	4.00	0.030	0.002	0.763			
	MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж	0.200	0.450	0.500			0.100			0.050					

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах "Хөтөл Цемент Шохой" ТӨХК-ний шохой, савлах, бутлуур, тээрэм, чулуунцарын цехийн орчмоос авсан агаарт азотын давхар исэл, хүхэрлэг хий, нарийн ширхэглэгт тоосонцор MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй бөгөөд нийт тоос Бутлуурын цех болон тээрэмийн цех орчимд 1.22-1.70 дахин давсан байна. Том ширхэглэгт тоосонцор (PM10)-ын агууламж MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас 3.8 дахин давсан байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-н инженер

Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн ерөнхий инженер

С.Цэнджав

М.Аягүл



Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

00011

Хөвчлэл - 1

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2023 /А32-36

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Сорилтын арга, аргачлал

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт

Шинжилгээ хийж дууссан огноо

"Хөтөл Цемент Шохой" ТӨХК

Сайхан сум

БОШЛ-ийн ерөнхий инженер М.Аягүл

6, Агаарын дээж

2023 - 05 - 22

MNS17.2.5.12:88, MNS17.2.511:88, MNS4048-88

хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос

2023 - 05 - 25

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м3										
		Азотын давхар исэл (NO2)	Хүхэрлэг хий (SO2)	Тоос (нийт)			Том ширхэглэгт тоосонцор (PM10)			Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)		
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
1	Шохойн цех	0.019	0.005	0.134	0.080	0.403						
2	Бутлуурын цех	0.011	0.004	0.217	0.088	1.04						
3	Тээрэмийн цех	0.027	0.011	0.842	0.279	6.81						
4	Савлах цех	0.044	0.015	0.277	0.168	1.18						
5	Чулуунцарын цех	0.021	0.006	0.174	0.171	0.216						
6	Төмөр зам	-	-	-	-	-	0.076	0.003	2.215	0.055	0.002	1.513
	MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж	0.200	0.450	0.500			0.100			0.050		

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах "Хөтөл Цемент Шохой" ТӨХК-ний шохой, савлах, бутлуур, тээрэм, чулуунцарын цехийн орчмоос авсан агаарт азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоос, том ширхэглэгт тоосонцор MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй бөгөөд нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ын агууламж MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас 1.1 дахин давсан байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-н инженер

Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн ерөнхий инженер



Т.Цэрэндолгор

М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно. Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Давуу - 2.

"Цемент шохой" ТӨХК-ийн агаарын чанарын 3-р сарын 21 хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр	Цементийн шатны дээвэр	Төмөр замын байр	Орон сууцны дээвэр
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	50	0 pptm	-	0 pptm	-
Нүүрстөрөгчийн дууу исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	10000	328 pptm	-	0 pptm	-
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	50	1.74 pptm	-	4.75 pptm	-
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	100	0.2 pptm	-	3.18 pptm	-
PM10 тоссонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	100	40 ug/m3	-	0 ug/m3	-
PM2.5 тоссонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	50	28 ug/m3	-	0 ug/m3	-

Дүгнэлт:

Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂), Нүүрстөрөгчийн дууу исэл(CO), Азотын дууу исэл(NO₂), Озон(O₃)-ны хүлцэх агууламж нь хэвийн байна.

Нарийн ширхэглэгт тоссонцор (PM2.5)-ын агууламж стандарт дахь хүлцэх хэмжээнээс үйлдвэрлэлийн бүс, сумын нутаг дэвсгэрт 1.61 дахин их байна.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нехэн сэргээлтийн мэргэжилтэн



Т.Уртнасан

“Цемент шохой” ТӨХК-ийн агаарын чанарын 4 сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархцатай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр	
				4.10	4.17
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		-4.5°C	6.1°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppm	0 ppm
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppm	328 ppm
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	5.19 ppm	5.35 ppm
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	2,16 ppm	2,3 ppm
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	36 ug/m ³	36 ug/m ³
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	26 ug/m ³	25 ug/m ³

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна.

4 сарын 28 өдөр агаарын температур тогтуун салхигүй, дулаан, солигдмол үүлтэй байсан.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т.Уртнасан

“Цемент шохой” ТӨХК-ийн агаарын чанарын 5 сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр		
				5.5	5.10	5.18
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		13.7°C	0.8°C	10.6°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppт	0 ppт	0 ppт
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppт	328 ppт	328 ppт
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	3.33 ppт	1.63 ppт	4.31 ppт
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	1.06 ppт	0.33 ppт	1.76 ppт
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	19 ug/m3	40 ug/m3	41 ug/m3
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	16 ug/m3	28 ug/m3	29 ug/m3

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), PM10, PM2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна. 5 сарын 5 өдөр агаарын температур тогтуун салхигүй, дулаан, солигдмол үүлтэй байсан. 5,10-ны өдөр цэлмэг салхигүй шөнө нь бороо орсон орчин чийгтэй байсан. 5,18-ны өдөр цаг агаарын байдал бүрхэг шуургатай шиврээ бороотой байлаа. 5,30-ны өдөр цаг агаарын байдал бүрхэг салхитай бороо орох шинжтэй байсан.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т. Уртнасан

"Цемент шохой" ТӨХК-ийн агаарын чанарын 6 дугаар сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр	
				6.15	6.19
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		11.9°C	17.4°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppт	0 ppт
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppт	328 ppт
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	1.96 ppт	0.71 ppт
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	0.46 ppт	0 ppт
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	49 ug/m3	41 ug/m3
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	35 ug/m3	29 ug/m3

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна.
6 сарын 15 өдөр 13.00 цагт хэмжилт бүртгэхэд солигдмол үүлтэй, чийгшил 57,1%, салхи 27км/ц хурдтай сэрүүхэн өдөр байлаа.

6 сарын 19 өдөр өглөө 06.51 минутанд хэмжилт бүртгэлээ өнөөдрийн цаг агаар тогтуун салхи 5км/ц хурдтай цэлмэг, чийгшил 97.9, агаарын температур 25 градус хүртэл хална.

6 сарын 26 өдөр өглөө 10:16 минутанд хэмжилт бүртгэлээ өнөөдөр цаг агаар тогтуун салхи 12 км/ц хурдтай үүлэрхэг чийгшил 76.1%, агаарын температур 23 градус хүртэл хална.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т.Уртнасан

"Цемент шохой" ТӨХК-ийн агаарын чанарын 7 дугаар сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр		
				7.03	7.07	7.17
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		13.2°C	20.2°C	32.4°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppt	0 ppt	0 ppt
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppt	328 ppt	328 ppt
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	1.14 ppt	0 ppt	0 ppt
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	0 ppt	0 ppt	0 ppt
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	40 ug/m3	42 ug/m3	40 ug/m3
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	29 ug/m3	29 ug/m3	28 ug/m3

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна.

2023.07.03-ны өдрийн дундаж температур 16 градус, гадаа бороотой, салхи 5км/ц тогтуун байна. Чийгшил 97,8

2023.07.07-ны өдрийн дундаж температур 22 градус, тэнгэр бүрхэг, салхи 15км/ц хурдтай байна. Чийгшил 77%.

2023.07.17-ны өдрийн дундаж температур 31 градус, цэлмэг, салхи 12км/ц хурдтай байна. Чийгшил 42%.

2023.07.31-ны өдрийн дундаж температур 25 градус, цэлмэг, салхи 15км/ц хурдтай байна. Чийгшил 80%.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



T. Уртнасан

"Цемент шохой" ТӨХК-ийн агаарын чанарын 8 дугаар сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр			
				8.01	8.07	8.14	8.23
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		17.3°C	20.2°C	23°C	21°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppт	0 ppт	0 ppт	0 ppт
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppт	328 ppт	328 ppт	328 ppт
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppт	0 ppт	0 ppт	0 ppт
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	0 ppт	0 ppт	0 ppт	0 ppт
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	40 ug/m3	45 ug/m3	41 ug/m3	41 ug/m3
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	29 ug/m3	33 ug/m3	29 ug/m3	29 ug/m3

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна.

2023.08.07-ны өдрийн дундаж температур 24 градус, бүрхэг, салхи 4км/ц хурдтай байна. Чийгшил 77%.

2023.08.14-ны өдрийн дундаж температур 22 градус, солигдмол үүлтэй, салхи 9км/ц хурдтай байна. Чийгшил 63%.

2023.08.23-ны өдрийн дундаж температур 21 градус, солигдмол үүлтэй, салхи 5км/ц хурдтай байна. Чийгшил 49%.

2023.08.25-ны өдрийн дундаж температур 23 градус, солигдмол үүлтэй, салхи 10км/ц хурдтай байна. Чийгшил 54.5%.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т. Уртнасан

"Цемент шохой" ТӨХК-ийн агаарын чанарын 10 дугаар сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр	
				10.18	10.25
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		8.8°C	2.4°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppm	0 ppm
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppm	328 ppm
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	2.45 ppm	3.55 ppm
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	0 ppm	1.4 ppm
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	41 ug/m3	40 ug/m3
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	32 ug/m3	29 ug/m3

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна. 2023.10.18-ны өдрийн дундаж температур 10 градус, бүрхэг, салхи 10км/ц хурдтай байна. Чийгшил 61%. 2023.10.25-ны өдрийн дундаж температур 2 градус, бүрхэг, салхи 2км/ц хурдтай тогтуун байна. Чийгшил 82%.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т.Уртнасан

"Цемент шохой" ХХК-ийн агаарын чанарын 11 дугаар сарын хэмжилт

MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хэмжилт

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Чулуунцарын офиссын дээвэр	
				11.1	11.15
Температур (°C)	Тухайн өдрийн	°C		-1.6°C	-2.9°C
Хүхэрлэг хий (SO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	0 ppm	0 ppm
Нүүрстөрөгчийн давхар исэл (CO)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/10000	328 ppm	328 ppm
Азотын давхар исэл (NO ₂)	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	4.69 ppm	4.69 ppm
Озон (O ₃)	7 хоногийн дундаж	мкг/м ³	8ц/100	1.96 ppm	2.26 ppm
PM10 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/100	45 ug/m ³	40 ug/m ³
PM2.5 тоосонцор	7 хоногийн дундаж	мкг/м ³	24ц/50	32 ug/m ³	30 ug/m ³

Дүгнэлт: Агаарын чанарын үзүүлэлтээр Хүхэрлэг хий(SO₂) хэмжигдэхгүй, Нүүрстөрөгчийн давхар исэл(CO), Азотын давхар исэл(NO₂), Озон(O₃), Pm10, Pm2.5-ууд хүлцэх агууламж нь хэвийн байна. 2023.11.1-ны өдрийн дундаж температур -2 градус, бүрхэг, салхи 18км/ц хурдтай байна. Чийгшил 97%. 2023.11.15-ны өдрийн дундаж температур -5 градус, солигдмол үүлтэй, салхи 2км/ц хурдтай цастай байна. Чийгшил 86%.

Бүртгэл хөтөлсөн:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн



Т. Уртнасан

"Цемент-Шохой" ТӨХК-ийн Цемент үйлдвэрийн ханцуйт фильтерийн хяналтын судалгаа

2023.11.15

№	Цех	Тоног төхөөрөмжийн нэр	Тип, марк	Ашиглалтанд орсон огноо	Фильтерийн уутны тоо	Фильтрийн уутны сольсон он	Фильтрийн уутны сольсон тоо
1-р тээрэм	Цементийн үйлдвэр	Ханцуйт фильтер M01/05	ФРКИ-360м2	1985	448ш	2016.04.28-29	448ш
						2017.04.16	112ш
						2017.08.27	16ш
						2018.03.09	2ш
						2018.08.24	6ш
						2020.04.09	448ш
						2021.03.10	480ш
						2022.08.27	448
						2023.07.28	20ш
2-р тээрэм	Цементийн үйлдвэр	Ханцуйт фильтер M02/05	PPCS96-5	2014	480ш	2016.03.29	480ш
						2016.05.16	2ш
						2016.08.03	480ш
						2017.05.01-02	192ш
						2017.07.04-05	480ш
						2017.07.18	190ш
						2017.08.05	6ш
						2018.07.24	8ш
						2018.08.21	6ш
						2020.07.23	480ш
						2022.08.26	480
						2023.07.28	14ш
						3-р тээрэм	Цементийн үйлдвэр
2016.11.02	4ш						
2017.02.28	28ш						
2017.07.03	480ш						
2017.09.21	17ш						
2017.10.23	2ш						
2018.03.02	2ш						
2018.07.03-04	480ш						
2018.08.23	4ш						
2020.07.24	245ш						
2021.03.20	280ш						
2023.02.15	480ш						
Нийт					1408		
						2021 он - 760ш	
						2022 он - 928ш	
						2023 он - 514ш	

2022 оны 10 дугаар сарын байдлаар 1, 2 дугаар тээрмийн ханцуйт фильтерийн 928ш фильтерийн уут солив.

2023 оны 4 дүгээр сарын байдлаар 3 дугаар тээрмийн ханцуйт фильтерийн 480ш фильтерийн уут сольсон.

2023 оны 10 дугаар сарын байдлаар 1, 2 дугаар тээрмийн ханцуйт фильтерийн 34ш фильтерийн уут сольсон.

Судалгаа хийсэн: Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн

 Т.Уртнасан

"Цемент шохой" ТЭХК-ийн Чулуунцарын үйлдвэр ханцуйт фильтерийн хяналтын судалгаа

2023.11.15

№	Цех	Тонг төхөөрөмжийн нэр	Тип марк	Ашиглалтанд орсон огноо	Фильтерийн уутны тоо	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1		G01/06 Шохойн чулууны бутлуур	Ø130x2450	2013-10 сар	672	672			672-8сар	
2		G02/11 Чулууны склад	Ø130x2450	2013-10 сар	96	96	96ш - 7сар		96-8сар	
3		G02/15 Чулууны склад	Ø130x2020	2013-10 сар	96	96	96ш - 8сар		96-8сар	
4		G03/13-1 Тохируулах силос	Ø130x2450	2013-10 сар	160			3ш - 3сар		
5		G03/13-2 Тохируулах силосын ханцуйт фильтер	Ø130x2450	2013-10 сар	160	Силос ажиллавал ашиглана. Одоогоор ашиглаагүй.				
6		G03/13-3 Тохируулах силосын ханцуйт фильтер	Ø130x2450	2013-10 сар	160			6ш - 3сар		
7		G03/16 Түүхий эдийн дамжлага	Ø130x2020	2013-10 сар	96			13ш - 3сар		
8		G03/17 Төмрийн хүдрийн бутлуурын ханцуйт фильтер	Ø130x2500	2013-10 сар	160			18ш - 2сар	128-8сар	
9		G04/19 Түүхий эдийн дамжлага	Ø130x2500	2013-10 сар	128					
10		G04/27 Хусуурт дамжлага	Ø130x2020	2013-10 сар	96				96-10сар	
11		G05/03 Ханцуйт фильтер	Ø160x6500	2013-10 сар	2816			12ш - 3сар		2816-2сар 5-9сар
12		G06/16 Жигдрүүлэх силос	Ø130x2450	2013-10 сар	160				160-8сар	
13		G06/18 Жигдрүүлэх силос	Ø130x2450	2013-10 сар	1256	620				
14		G11/02 Нүүрсний дамжлага	Ø130x2020	2013-10 сар	96					
15		G12/08-а Нүүрсний склад	Ø130x2450	2013-10 сар	96					142-2сар
16		G12/08-б Нүүрсний склад	Ø130x2450	2013-10 сар	96					
17		G12/07- Нүүрсний складын ханцуйт фильтер /туузан дамжлага/	Ø130x2466	2013-10 сар	96					96-2сар

18	G13/10 Нүүрсний тээрэм	Ø130x3060	2013-10 сар	768	768	768	21ш - 3сар 4ш - 4сар 768ш - 5сар	400-2сар	
19	G13/20 Нүүрсний тээрэм	Ø130x2020	2013-10 сар	96	96	96	2ш - 3сар	96-2сар	
20	G13/22 Нүүрсний тээрэм	Ø130x2450	2013-10 сар	128	128	128		128-2сар	
21	G11с Нүүрсний бутлуур	Ø130x2450	2013-10 сар	160	160			128-3сар	
22	G14a/2 Клинкерийн дамжлага	Ø130x2450	2013-10 сар	160	160	160ш - 6сар, 160ш - 9сар		78-2сар	
23	G14a/1 Клинкерийн дамжлага	Ø130x2450	2013-10 сар	128	128	128ш - 6сар, 128ш - 9сар	26ш - 2сар		
	Нийт						7880	873	3889

Нийт 23 ханцуйт филтерээс 22 нь ажилладаг. 2019 оны үзлэг шалгалтаар 9 филтерийн 2764ш уут сольсон.

Нийт 23 ханцуйт филтерээс 22 нь ажилладаг. 2020 оны үзлэг шалгалтаар 4 филтерийн 768ш уут сольсон.

Нийт 23 ханцуйт филтерээс 22 нь ажилладаг. 2021 оны үзлэг шалгалтаар 8 филтерийн 873ш уут сольсон.


Нийт 23 ханцуйт филтерээс 22 нь ажилладаг. 2022 оны үзлэг шалгалтаар 6 филтерийн 1248ш уут сольсон.

Нийт 24 ханцуйт филтерээс 23 нь ажилладаг. 2023 оны үзлэг шалгалтаар 8 филтерийн 3889ш уут сольсон.

Судалгаа хийсэн: Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн

 Т.Уртнасан

2023 оны Нийт ажилтны сургалт, гарын авлага





БАНГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУРЛАЛЫН ЯАМ
ОРХОН-ЧУДУУТ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 8/18

Эрдэнэбулган сум

Зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "УСНЫ ГАЗАР"-ын гаргасан 2023 оны 06 сарын 13-ны өдрийн 132 дугаар Ус ашиглуулах дүгнэлт, Хөтөлийн "Цемент шохой" ТӨХК-ний 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/836 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумдын нутагт Дархан хотоос баруун урагш 65км-т шохойн чулуу олборлож, цемент шохой, дулаан үйлдвэрлэдэг Хөтөлийн "Цемент шохой" ТӨХК-нд унд ахуйн 37,867.5м³/жил, Цемент шохойн үйлдвэрлэлд ашиглах 290,696.7м³/жил, дулаан үйлдвэрлэлд ашиглах 173,002.53м³/жил, ерөмдлөгт ашиглах 5,800.0м³/жил, зам талбайн усалгаанд 27,000.0м³/жил биологийн нөхөн сэргээлтэд ашиглах 960.0м³/жил газрын доорх усыг нэг жилийн хугацаатайгаар ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (Ү.Очирдулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ОТГОНБААТАР
5515901481 3008994

Ч.ОТГОНБААТАР

БАТЛАВ:
ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА


Ч.ОТГОНБААТАР

БАТЛАВ:
“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Л.НАРАНБААТАР

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар - 06

2023 оны 07 дугаар
сарын 31ний өдөр

Эрдэнэбулган сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газрын 2023 оны 06 дүгээр сарын 13 -ны өдрийн 132 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны даргын олгосон 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/18 тоот ус ашиглуулах зөвшөөрлийг үндэслэн

Ус ашиглуулагчийг төлөөлж Орхон-Чулуут голын сав газрын захиргааны доорх усны нөөц хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Үүрцайх овогтой Очирдулам, Ус ашиглагчийг төлөөлж Сэлэнгэ аймаг Сайхан сум Хөтөл баг 9012001033 улсын бүртгэлийн дугаар 2641984 регистрийн дугаартай “Цемент шохой” ТӨХК-ний гүйцэтгэх захирал Л.Наранбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Сэлэнгэ аймгийн Сайхан суманд шохойн чулуу олборлож, цемент шохой, дулаан үйлдвэрлэнэ. Чулуунцарын үйлдвэр, цементын үйлдвэр, шохойн үйлдвэр, геологи уул уурхай, дулааны станц гэсэн үндсэн цехүүдтэй.

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. Үйлдвэрлэлд ашиглах нийт усны хэрэгцээг Хөтөл тосгоны усаар хангагч байгууллага болох “Гавшгай-ус” ХХК-наас гэрээгээр болон өөрийн 2 худгаас хангана. Хоногт унд ахуйд 114.75м³ ус ашиглана.

2.3. Усны чанар, найрлага эх үүсвэр: Орхон голын хөндийд орших 50-57м гүнтэй 50-83л/сек ундрагатай 5 ширхэг гүний худгаас Гавшгай ус” ХХК нь усаа түгээдэг.

2.4. Усны барилга байгууламж: 4000.0м³ эзлэхүүнтэй 2ш усан сантай. Худгаас 60м урт, 50мм гөлчтой хоолойгоор ус татна.

2.4.1. **Тоног төхөөрөмжийн нэр, марк, Насосны хүчин чадал:**

- Худагуудад ЭЦВ6-6.5-120 маркийн насос, LXLG маркын тоолууртай.

2.5 Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

2.10.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “УСНЫ ГАЗАР”-ын дүгнэлтээр урьдчилсан байдлаар гаргасан Цемент шохойн үйлдвэрлэлд ашиглах 290,696.7м³/жил газрын доорх усны 57,499,807.26 төгрөг, дулаан үйлдвэрлэлд ашиглах 173,002.53м³/жил газрын доорх усны 12,831,597.65 төгрөг, өрөмдлөгт ашиглах 5,800.0м³/жил газрын дорх усны 6,883,440.0 төгрөг, зам талбайн усалгаанд 27,000.0м³/жил газрын доорх усны 5,340,600.0 төгрөг, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах 960.0м³/жил газрын доорх усны 71,203.2 төгрөгийг тус тус ногдуулсан байна.

2.6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор Сэлэнгэ аймгийн Төрийн сангийн дансанд төлж барагдуулна. Усны нөөц ашигласны төлбөр олсон баримтын

Ус ашиглуулагчийг төлөөлж...



1/2

Ус ашиглагчийг төлөөлж...



ЦЕМЕНТ ШОХОЙ
ХХК
2023.09.15

хуулга, усны дээжинд хийсэн шинжилгээний дүн, зэргийг Орхон-Чулуут голын сав газрын захиргаанд тухай бүр ирүүлнэ. Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

2.7. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох бохирдуулах бодисын хэмжээ:

Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, Архангай аймгийн байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улиарал бүр сав газрын захиргаанд ирүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1 Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 18.1.4, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол

4.6 Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд ус зөвшөөрөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

 /Y.Очирдулам/


Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум, 3-р баг, Монгол даатгалын байр Орхон-Чулуут голын сав газрын захиргаа
Харилцах утас: 70333764, 99208331

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"Цемент шохой" ТӨХК-ний ерөнхий инженер бөгөөд үйлдвэрлэл технологийн газрын дарга

 /Н.Буян-Олзий/

Санхүү, эдийн засгийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч

 /М.Оюунтуяа/

Хяналдан авах ажиллагааны хэлтсийн дарга

 /Д.Амгаланбаяр/

Хуулийн хэлтсийн дарга

 /П.Занабазар/

Дулаан хангамжийн мэргэжилтэн


 /Т.Эрдэнэчимэг/

Хаяг: Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл 1-р баг үйлдвэрлэлийн район өөрийн байр
Харилцах утас: 70368151

Ус ашиглуулагчийг төлөөлж 

Ус ашиглагчийг төлөөлж:

ХАЙН
13 оны 09 сар 05
...



**ЦЭВЭР УСААР ХАНГАХ БОЛОН БОХИР УСЫГ
ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 08-р сарын 25-ны өдөр

БГ/23/...

Хөтөл хот

Нэг талаас Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл 1-р баг, үйлдвэрийн район, өөрийн байх хаягт байрлах **"Цемент Шохой" ТӨХК** (Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл-Цемент, шохой, дулаан үйлдвэрлэл, Улсын бүртгэлийн №9010001106, регистрийн №2641984, цаашид **"Хэрэглэгч"** гэх), түүнийг төлөөлж Дулаан, ус, сантехник хариуцсан мэргэжилтэн Т.Эрдэнэчимэг,

нөгөө талаас Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл 1-р багт байрлах **"Гавшгай Ус" ОНӨААТҮГ** (Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл-Цэвэр ус олборлох, бохир ус татан зайлуулах, Улсын бүртгэлийн №1311004080, регистрийн №2056194, цаашид **"Хангагч"** гэх), түүнийг төлөөлж Ерөнхий инженер Ү.Эрдэнэцэцэг нар доорх нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заагдсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага /хангагч/ болон үйлчилгээг хүртэж буй байгууллага /хэрэглэгч/-ын хоорондын харилцаа, түүнд тавих шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл зэргийг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээний хугацаа 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хүчинтэй.
- 2.2 Энэхүү гэрээ нь батлагдсан өдрөөс эхлэн аль нэг талаас гэрээг албан ёсоор цуцлах хүртэлх хугацаанд хүчинтэй.

Гурав. Хэрэглээг тодорхойлох тухай

- 3.1 Цэвэр усны тооцоог үйлдвэрийн районд суурилуулсан "Гавшгай Ус" ОНӨААТҮГ-ын хэмжих хэрэгслээр тооцно. Хэрэглэгч, Хангагч талын хэмжих хэрэгслүүдийн алдаа 2 хувиас хэтэрсэн тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. Тоолуурын заалтын бичилтийг сарын эцэст "Гавшгай Ус" ОНӨААТҮГ-ын эрх бүхий ажилтан Хэрэглэгчийн төлөөлөгчийг байлцуулан бичилт хийнэ.
- 3.2 Тоолуур ажиллахгүй болсон тохиолдолд цэвэр усны хэрэглээ татан зайлуулсан бохир усны хэмжээг өмнөх 3 сарын дунджаар тооцно.
- 3.3 Үйлдвэрийн доторх объектуудын цэвэр усны хэрэглээг тоолуураар тодорхойлно. Тоолуургүй объектуудыг ус хэрэглээний норм үндэслэн тооцно.
- 3.4 "Цемент Шохой" ТӨХК нь гүний худаг ажиллаагүй үед үйлдвэрлэлд цэвэр ус зарцуулбал Компрессор болон Чулуунцарын үйлдвэр талын тоолуурын заалтыг Хангагч байгууллагаар шалгуулсан тохиолдолд бохир ус тооцохгүй, "Хөтөл энержи дулаан" ХХК-ийн технологийн бохир усыг сүлжээний нэмэлт усны тоолуурын заалтын зөрүүгээр, ахуйн бохир усыг цэвэр усны тоолуурын заалтыг үндэслэн тус тус тооцно.

Дөрөв. Хэрэглэгчийн хүлээх эрх үүрэг

- 4.1 "Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль", "Монгол улсын усны тухай хууль", "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 2.5.1, 2.5.2, 2.5.3, 2.6, 4.6, 4.8, 4.14-р зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 4.2 Хэрэглэгч нь "Гавшгай Ус" ОНӨААТҮГ -ын эрх бүхий хүмүүс /ИТА/-ийг цэвэр усны шугамын оруулга ЦТП, Усны хэмжүүрийн зангилаа, ариутгах татуургын шугам, худаг камер, сантехникийн хэрэгслийн ашиглалтын байдалд үзлэг хийх бололцоогоор хангана.

Хэрэглэгчийг төлөөлж:



1/5

Хангагчийг төлөөлж:

...

- 4.3 Хэрэглэгч нь урьд авсан техникийн нөхцөлийг хэрэглээ өсөхөөр өөрчлөх, шинээр шугам сүлжээнд холболт хийх зэрэг үйл ажиллагааг зөвхөн "Хангагчид" урьдчилан мэдэгдэж шинээр техникийн нөхцөл авч гүйцэтгэнэ. Хэрэглэгч нь урьд авсан техникийн нөхцөлд заагдсан хэрэглээг нэмэгдүүлэхгүй өсгөхгүйгээр холболтыг өөрчилж болно.
- 4.4 "Цемент Шохой" ТӨХК-ийн үйлдвэрийн талбай дахь "Хангагч"-ийн эзэмшлийн бохир усны худгуудын бүрэн бүтэн байдлыг хангаж ариутгах татуургын шугам сүлжээг бөглөрөлт, гэмтлээс хамгаалах үүрэг хүлээнэ. Шаардлагатай үед хангагчид мэдэгдэж засвар үйлчилгээ хийлгэх арга хэмжээ авахуулах ба мэдэгдсэн боловч зохих арга хэмжээг аваагүйгээс гарах эрсдэл хохирлыг хариуцахгүй.
- 4.5 Өөрийн зааг эзэмшилд байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ барилга байгууламжийг найдвартай хамгаалалтаар хангах, тэдгээрийг гэмтээхгүй, усанд автуулахгүй, хөлдөөхгүй байлгах, худгийн тагийг цас мөснөөс хамгаалах цэвэрлэх, хангагч байгууллагаас тавьсан лац, ломбыг гэмтээхгүй байх, гадаргуугийн болон хур тунадасны ус зайлуулах сувгийг ариутгах татуургын шугам сүлжээнд холбохгүй, галын гидрантын ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангах, ус зөөвөрлөх боломжтой орц гарцтай байна.
- 4.6 Өөрийн эзэмшлийн цэвэр, бохир усны шугам, худгийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж, стандартын тагтай байлгах ба техникийн узель, зоорийн давхарт бараа материал хурааж зориулалтын бусаар ашиглахыг хатуу хориглоно.
- 4.7 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид гарсан осол гэмтлийн талаар хангагч байгууллагад яаралтай мэдэгдэж, хангагчийн төлөөлөл ирэх хүртэл гэмтэл гарсан хэсгийг хяналтандаа байлгана.
- 4.8 Хэрэглэгч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зөвшөөрөгдөх хэмжээнд нийцсэн бохир усыг төвлөрсөн шугамд нийлүүлнэ.
- 4.9 Хэрэглэгч нь МК8 4943:2011 "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага" стандартын шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усыг байгальд нийлүүлнэ.
- 4.10 Худаг, камерийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гадны хүн оруулахгүй байна.
- 4.11 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр холбогдож, эрх бүхий ажилтны хяналтан дор холболтыг гүйцэтгэнэ.
- 4.12 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоноглолд усны алдагдал гаргахгүй, эргэлтийн /хөргөлтийн/ усыг халиулахгүй байх үүрэг хүлээнэ. Сүлжээнд шинээр холбогдох, таслуулах, холболтыг өөрчлөх тухай хэрэглэгчийн захиалгыг хангагч судлан үзэж, техникийн нөхцөл шаардлага хангасан гэж үзвэл 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 4.13 Хэрэглэгч нь тухайн сард хэрэглэсэн усны төлбөрөө бэлэн болон хоорондын тооцоогоор (бэлэн бусаар) барагдуулах болно.

Тав. Хангагчийн эрх, үүрэг

- 5.1 "Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль", "Монгол Улсын усны тухай хууль", "Аж ахуйн харилцааны" дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 5.2 Хангагч нь Хот суурины ус хангамж, Ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2, 13.3-т заасны дагуу хэрэглэгчтэй гэрээ хийнэ.
- 5.3 Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон шугам сүлжээ, барилга байгууламжид хяналттавьж, хэрэглэгчдэд ашиглалтын талаар мэргэжлийн тусламж, зөвлөгөө өгнө.
- 5.4 Хэрэглэгчийн усны зүй бус хэрэглээг илрүүлэх, усны алдагдлыг таслан зогсоох, усыг хэмнэлттэй хэрэглэх бодлого баримтлах, хэрэглэгчийн нийлүүлж буй бохир усанд лабораторийн шинжилгээ хийж, байнгын хяналт тавина.

Хэрэглэгчийг төлөөлж



2/5

Хангагчийг төлөөлж

- 5.5 Хангагч нь төвийн цэвэр усны шугамын даралтыг 2 ата-аас бууруулахгүй байна.
- 5.6 Хангагч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хэмжээг үйлдвэрлэл явуулж буй хэрэглэгчийн нийлүүлж байгаа технологийн бохир уснаас сар бүр дээж авч шалгана.
- 5.7 Хангагч нь хэрэглэгчдийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дах хэсэгт заасны дагуу батлагдсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа МИ8 0900:2005 (хууль зүйн яаманд бүртгэлгүй байгаа учраас) “Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” ундны усны стандартын шаардлагад нийцсэн усаар хангана.
- 5.8 Цэвэр бохир усны үнэ тариф өөрчлөгдөх тухай бүр түүнийг мөрдөж эхлэхээс 5 хоногийн өмнө албан ёсоор хэрэглэгчид мэдэгдэнэ.
- 5.9 Хангагч нь ачааллын дутагдалд орж хэрэглэгчийг цэвэр усаар хангах боломжгүй болсон тохиолдолд горимын болон ачааллын зохицуулалт яаралтай хийж ажиллана.
- 5.10 Хэрэглэсэн цэвэр ус, нийлүүлсэн бохир усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй ба үйлдвэрлэлийн ачааллын үед цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үүргээ тасралтгүй гүйцэтгэнэ.
- 5.11 Хэрэглэгчээс гарсан санал хүсэлтийг шуурхай барагдуулна.

Зургаа. Хэрэглээг тодорхойлох тухай

- 6.1 Хэрэглэгчийн усны тоолуур гэмтсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, засварлуулах арга хэмжээг авах үүрэгтэй.
- 6.2 Хэрэглэгч усны нөөц тоолууртай бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчийг байлцуулан сольж заалтыг 2 тал баталгаажуулна.
- 6.3 Тоолуур ажиллахгүй болсон тохиолдолд цэвэр усны хэрэглээ татан зайлуулсан бохир усны хэмжээг өмнөх 3 сарын дунджаар тооцно.
- 6.4 Үйлдвэр доторх объектуудын цэвэр усны хэрэглээг тоолуураар тодорхойлно. Тоолуургүй объектуудыг ус хэрэглээний норм үндэслэн тооцно.
- 6.5 Үйлдвэрлэлд зарцуулсан цэвэр усны хэмжээг тоолуурын заалтаар тооцно. /Бохир ус тооцохгүй/
- 6.6 Үйлдвэрийн нийт цэвэр усны хэрэглээг “Цемент шохой” ТӨХК болон “Гавшгай Ус” ОНӨААТҮГ - ын төв тоолуурын зарцуулалтыг үндэслэн тодорхойлж тооцно.

Долоо. Төлбөр тооцоо

- 7.1 Сар бүрийн 3-ны өдрийн дотор 2 талын төлөөлөгч /гэрээ байгуулсан/ хамтран сарын хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулж цэвэрлэсэн бохир усны тооцоог хийж, улиралд нэг удаа дүгнэж протокол үйлдэж 2 талын дарга, захирлаар батлуулан баталгаажуулна.
- 7.2 “Цемент Шохой” ТӨХК-ийн үйлдвэрийн технологиос гарч байгаа бохир усны найрлага нь шугаманд нийлүүлэх үед зөвшөөрөгдсөн нормоос /Монгол улсад мөрдөгдөж буй/ хэтэрсэн байвал бохирдуулагч этгээд /хэрэглэгч/ нэмэгдэл тарифаар төлөх зарчмыг баримтлан төлбөр төлнө.
- 7.3 Хот суурин ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс усны үнэд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээний үнэд тодотгол хийнэ.
- 7.4 Цэвэр бохир усны хэрэглээг тоолуураар тооцож, хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөр батлагдсан усны болон суурь үнээр тооцно. (Цементийн үйлдвэрлэл явуулах аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулж байгаа 1м³ цэвэр усанд 3800 төгрөг, бохир усанд 3800 төгрөг, суурь үнийг 104,400 төгрөг НӨАТ ороогүй)
- 7.5 Усны зарцуулалтын хэмжих хэрэгсэл нь Монгол Улсын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан байна.
- 7.6 Хэрэглэгч нь тухайн сард хэрэглэсэн усны төлбөрөө бэлэн болон хоорондын тооцоогоор (бэлэн бусаар) дараа сарын 10-ны өдрийн дотор төлнө. Цаашид үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд цэвэр усаар хангах бохир усыг татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлана.

Хэрэглэгчийг төлөөлж: *[Signature]*

3/5

Хангагчийг төлөөлж: *[Signature]*



**Найм. Цэвэр бохир усны шугам сүлжээний ашиглалт
эзэмшлийн зааг хязгаар**

8.1 "Хангагч"-ийн хариуцан эзэмшиж ашиглах хязгаар:

- Цэвэр усны шугам сүлжээг цэвэр усны "ВК-3" камерт /Цемент шохой" ТӨХК-ийн төв харуулын байрны дэргэдэх/ суурилагдсан Эстекад талын Ду -300мм-ийн хаалтнаас "ВК-2" камерт суурилагдсан компрессор талын Ду-300мм-ийн хаалт таслах хаалт хүртэлх шугам сүлжээ;
- Цемент шохой ТӨХК-ийн Засварын нэгдсэн цехийн үүдэнд байрлах "ВК-12" камер дахь таслах хаалтнаас /Вокзал талын/ шугам сүлжээ.

8.2 Төв гал команд, вокзалын хашааны сүлжээнээс "Цемент шохой" ТӨХК-ийн хашаан дотуур явсан Ариутгах татуургын худгуудыг дамжин К-1 худаг хүртэлх гол коллекторыг "Гавшгай-Ус" ОНӨААТҮГ эзэмшинэ.

8.3 Хэрэглэгчийн хариуцан эзэмшин ашиглах хязгаар:

- "ВК-2", ВК-3", ВК-12"-оос цааш /Цемент шохой ТӨХК-ийн хашаан доторх/ цэвэр усны 2 цагираг сүлжээ;
- Дээрх буюу 8.2-т зааснаас бусад Цемент шохой ТӨХК-ийн хашаан доторх болон УАТЦ-ийн хашаан дахь ариутгах шугам сүлжээ.

Ес. Ус хангамжийг хязгаарлах нөхцөлүүд

9.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хангагч нь хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлана.

9.2 Хангагч байгууллага нь ямар ч тохиолдолд хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлахдаа урьдчилан заавал мэдэгдэнэ. /Аваар, осол, гэмтэл гарсан тохиолдолд тухайн үед нь мэдэгдэнэ./

9.3 Хэрэглэгч нь хангагч байгууллагаас албан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд дамжин хэрэглэгчийн усыг хаах болон таслах эрхгүй.

9.4 Хангагч байгууллага нь хэрэглэгчдийг цэвэр усаар хангах, татан зайлуулах ажиллагааг тодорхой хугацаанд хэсэгчлэн болон бүрэн зогсоож болно. Үүнд:

- Бохир усны найрлага дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээнээс ихийг цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн;
- Бохирдолтын түвшинг баримтлаагүй тохиолдолд дээрх заалтыг хүчин төгөлдөр мөрдөнө.

9.5 Хэрэглэгчид усны хэрэглээг хязгаарлах тухай мэдэгдлийг хангагчийн эрх бүхий ажилтан 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

9.6 Хязгаарлах үйл ажиллагааг хангагчийн эрх бүхий ажилтан хийж гүйцэтгэнэ.

**Арав. Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал
үүссэн нөхцөлд ажиллах**

10.1 Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хангагч өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллана.

10.2 Хангагч нь байгаль цаг уурын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан шугам сүлжээнд гарсан осол, гэмтлийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээ авах, шаардагдах засварын хугацааг хэрэглэгчдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдээлнэ.

10.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт заасан гамшгийн нөхцөл байдал үүссэнээс бусад үед буюу шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарснаас хэсэг бүлэг хэрэглэгчдийн ус хангамж тасарсан тохиолдолд хэрэглэгчид мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор хэрэглэгчийн ус хангамжийг сэргээнэ.

Арван нэг. Маргааныг хянан шийдвэрлэх, хохирлыг нөхөн төлүүлэх.

11.1 Хангагч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

11.2 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтад заасны дагуу өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хянан шийдвэрлэнэ.

Хэрэглэгчийг төлөөлж: _____

4/5

Хангагчийг төлөөлж: _____



- 11.3 Хангагч нь хэрэглэгчээс гаргасан өргөдөл гомдлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 11.4 Хангагч, хэрэглэгчийн хооронд гарсан маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу шийдвэрлэх бөгөөд харилцан шийдэлд хүрч чадаагүй тохиолдолд Зохицуулах зөвлөлд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. Хэрэв маргалдагч талууд Зохицуулах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлнэ.
- 11.5 Хангагч, хэрэглэгчийн хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбоотой гарсан маргааныг шийдвэрлэхдээ стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дүгнэлт гаргуулна.
- 11.6 Хангагч, хэрэглэгчийн хооронд цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулахтай холбоотой харилцаанаас үүссэн хохирлыг хангагч хэрэглэгчийн хамтран тогтоосон актаар баталгаажуулна.
- 11.7 Хохирлын актыг холбогдох талууд хамтран ажлын 5 /тав/ хоногийн дотор тогтоож баталгаажуулах бөгөөд хохирлыг буруутай тал нь 1 /нэг/ сарын дотор төлнө.
- 11.8 Хангагч гэрээний үүргээ биелүүлээгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ус хангамжийг тасалдуулсны улмаас хэрэглэгчид учирсан хохирлыг бүрэн нөхөн төлнө.
- 11.9 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад этгээдэд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлнө.

Арван хоёр. Бусад зүйл

- 12.1 Энэхүү гэрээний биелэлтэд хангагч, хэрэглэгч талууд болон Зохицуулах зөвлөл хяналт тавина.
- 12.2 Энэхүү гэрээг зөрчсөн этгээдэд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 12.3 Хангагч байгууллага нь өөрийн эзэмшлийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд тэдний хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУДСАН:

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер бөгөөд үйлдвэрлэл,
Технологийн газрын дарга

Н.БУЯН-ӨЛЗИЙ

Санхүү, эдийн засгийн газрын даргын
үүргийг хавсран гүйцэтгэгч

М.ОЮУНТУЯА

Худалдаагаах ажиллагааны хэлтсийн дарга

Д.АМГ АЛАНБАЯР

Худалдаа хэлтсийн дарга

П.ЗАНАБАЗАР

Дулаан хангамж харнууцсан мэргэжилтэн

Т.ЭРДЭНЭЧИМЭГ

ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер

Ү.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Ерөнхий нягтлан бодогч

Ё.БАТЦЭНГЭЛ

Хэрэглэгчийг төлөөлж: *[Signature]*

Хангагчийг төлөөлж: *[Signature]*



Лавцалт - 6.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036- 3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2022 / № У30-31

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймаг Орхон сумын засаг дарга Г.Бат-Орхон (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Цемент шохой" ТӨХК (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Л.Наранбаатар нар Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйл, 42 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179 дугаар тогтоолыг тус тус үндэслэн (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Сэлэнгэ аймаг Орхон суманд байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймаг Орхон сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглахтай холботой болон бусад дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр аливаа хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;
- 2.1.2. энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;
- 2.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;
- 2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.
- 2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан өргөдлийн дагуу уурхайн эдэлбэр газрыг 2023 онд багтаан олгох.
- 2.1.7. уурхайн эдэлбэр газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглуулахад санал өгөхгүй байх.

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах, нээлттэй ажлын байранд өрсөлдөх боломжийг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.4. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.5. уул уурхайн үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх (Ногоон зурвас байгуулахад 3000 ширхэгээс багагүй тарьц суулгацын дэмжлэг 10 дугаар сард үзүүлэх)

3.1.6. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техникийн туслалцаа үзүүлэх, Үерт өртсөн зам тэгшилэхэд техникийн туслалцаа үзүүлэх,

3.1.7 бээлий, дэрсэн шүүр, хормогч болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тус орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийг оролцуулан "Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ын дагуу гэрээ байгуулж болно.

3.1.8. Бэлэндалай багийн 42-р зөрлөгөөс Шийр хооронд байрлах хайрган хучилттай 2.3 км замын хайрган хучилтыг сэргээн засварлах,

3.1.9. Сумын хэмжээний зохион байгуулагдах спортын тэмцээнийг Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу хамтран зохион байгуулах.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж болно.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

НАЙМ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1(Нэг) жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА

Бат-Орхон
Т. БАТ-ОРХОН

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.Ганчимэг
Ш. ГАНЧИМЭГ

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

М.Хулан
М. ХУЛАН

Хэвлэл мэдээллийн ажилтан

Б.Хонгорзул
Б. ХОНГОРЗУЛ

ЦЕМЕНТ ШОХИЙ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ

Л.Наранбаатар
Л. НАРАНБААТАР

Ерөнхий инженер бөгөөд үйлдвэрлэл
технологийн газрын дарга

Н.Буюн-Өлзий
Н. БУЯН-ӨЛЗИЙ
Вахиогаа удирдлагын газрын дарга

Д.Ихбаяр
Д. ИХБАЯР
Геологи, уул уурхайн хэлтсийн дарга

Б.Ууганбаяр
Б. УУГАНБАЯР
Хуулийн хэлтсийн дарга

П.Занабазар
П. ЗАНАБАЗАР

Лавсан - 19.



Огноо/Date: 2023.11.13 08:17:05

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000584448383

Системийн огноо/System Date: 2023.11.10 15:03:10

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5048372897	ЦЕМЕНТШОХОЙ ТӨХК	6,225,000.00 MNT	1.00
/ Зургаан сая хоёр зуун хорин таван мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	90	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа	6,225,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Цемент шохой төхк байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр 2023 он

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэр/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)



ИРГЭН... *Монхтөстөх*... ТАНД

**“ЦЕМЕНТ ШОХОЙ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

Хөтөл 1-р баг, Сайхан сум, Сэлэнгэ аймаг 43131
Утас: 7036-8151, Факс: (976) 7036-8368
И-мэйл: info@khutulcement.mn

2023.08.16 № *02/1056*

танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэх хуудас

Цемент шохой ТӨХК-ийн түүхий эд олборлодог Хөтөл-1, Хөтөл-2 ордууд, үйлдвэрийн харьяалалтай тусгай зөвшөөрөлтэй талбай, тэдгээрийг холбосон шохойн чулууны бутлуур хүртэлх технологийн зам, уурхайн үйлдвэрлэлийн бүс, талбайг тойрсон мал, айл олноор байрлаж, авто болон ердийн хөсгөөр малчид өдөр бүр технологийн зам талбайгаар зорчиж байна.

МАЛЧИН ТА ил уурхайн бүсэд /тэсэлгээний аюултай бүсэд/ орж ирэх, технологийн замаар дур мэдэн зорчиж, малаа уурхайн бүс, талбай руу бэлчээж байгаа нь аливаа аваар осолд өртөх өндөр эрсдэл үүсгэж, тээвэрлэлт болон тэсэлгээ хийх ажилд саад учруулж байгаа тул уурхайн бүсрүү малаа бэлчээхгүй байх, уурхайн бүсээс 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор яаралтай нүүх шаардлагатайг мэдэгдэж байна.

Иймд дараах зүйлсийг анхааруулж байна.

-Уг хашаажуулсан бүсрүү мал оруулах, явганаар болон машин техник, морьтой зорчсоноос шалтгаалан технологийн замд осол гарах, мал эд хөрөнгөний хохирол учрах ба хүний эрүүл мэнд, амь насанд гэмтэл, хохирол учруулсан тохиолдолд Цемент шохой ТӨХК хариуцахгүй болохыг албан ёсоор мэдэгдэж байна.

-Хэрэв дээрх нөхцөл байдлаас шалтгаалан компанийн машин техникт хохирол учирсан тохиолдолд хохирлыг төлүүлэх, мөн малыг хашиж нөхөн төлбөр гаргуулах буюу хууль хяналтын байгууллагад асуудлыг тавьж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэн ажиллах болно.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА *Н.Буян-Өлзий* Н.БУЯН-ӨЛЗИЙ





ИРГЭН Ажиглагч ТАНД

**“ЦЕМЕНТ ШОХОЙ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

Хөтөл 1-р баг, Сайхан сум, Сэлэнгэ аймаг 43131
Утас: 7036-8151, Факс: (976) 7036-8368
И-мэйл: info@khutulcement.mn

2023.08.16 № 02/1056

танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэх хуудас

Цемент шохой ТӨХК-ийн түүхий эд олборлодог Хөтөл-1, Хөтөл-2 ордууд, үйлдвэрийн харьяалалтай тусгай зөвшөөрөлтэй талбай, тэдгээрийг холбосон шохойн чулууны бутлуур хүртэлх технологийн зам, уурхайн үйлдвэрлэлийн бүс, талбайг тойрсон мал, айл олноор байрлаж, авто болон ердийн хөсгөөр малчид өдөр бүр технологийн зам талбайгаар зорчиж байна.

МАЛЧИН ТА ил уурхайн бүсэд /тэсэлгээний аюултай бүсэд/ орж ирэх, технологийн замаар дур мэдэн зорчиж, малаа уурхайн бүс, талбай руу бэлчээж байгаа нь аливаа аваар осолд өртөх өндөр эрсдэл үүсгэж, тээвэрлэлт болон тэсэлгээ хийх ажилд саад учруулж байгаа тул уурхайн бүсрүү малаа бэлчээхгүй байх, уурхайн бүсээс 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор яаралтай нүүх шаардлагатайг мэдэгдэж байна.

Иймд дараах зүйлсийг анхааруулж байна.

-Уг хашаажуулсан бүсрүү мал оруулах, явганаар болон машин техник, морьтой зорчсоноос шалтгаалан технологийн замд осол гарах, мал эд хөрөнгөний хохирол учрах ба хүний эрүүл мэнд, амь насанд гэмтэл, хохирол учруулсан тохиолдолд Цемент шохой ТӨХК хариуцахгүй болохыг албан ёсоор мэдэгдэж байна.

-Хэрэв дээрх нөхцөл байдлаас шалтгаалан компанийн машин техникт хохирол учирсан тохиолдолд хохирлыг төлүүлэх, мөн малыг хашиж нөхөн төлбөр гаргуулах буюу хууль хяналтын байгууллагад асуудлыг тавьж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэн ажиллах болно.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Н.БУЯН-ӨЛЗИЙ



ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2023-08-30

Дугаар: 0002510

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9012001033

Регистрийн дугаар: 2641984

Хаяг: Сэлэнгэ, Сайхан сум, 1-р баг, Хөтөл

Утас: 70368151

Дараах химийн хортой, аюултай бодис:

Ашиглах

2023.08.30 -2028.08.30

тусгай зөвшөөрлийг

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томъёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 68 нэр төрөл бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт:

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Төрийн нарийн бичгийн дарга /ын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

С.ЦОГТГЭРЭЛ /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.БАТЖАРГАЛ /

29	Фосфорын хүчил	Phosphoric acid	H_3PO_4	7664-38-2	300
30	Стеарины хүчил	Stearic acid	$CH_3-(CH_2)_{15}-COOH$	57-11-4	30
31	Этиленгликол	Ethylene glycol	$C_2H_6O_2$	107-21-1	220
32	Хүхрийн хүчил	Sulfuric acid	H_2SO_4	7664-93-9	100
33	Калийн бихромат	Potassium dichromate	$K_2Cr_2O_7$	7778-50-9	5
34	Метилоранж	Methyl orange	$C_{14}H_{14}N_3NaO_3S$	547-58-0	0.5
35	Индикатор	Sodium - dephenylamine sulfinate	$C_{12}H_{10}NNaO_3S$	6152-67-6	0.5
36	Индикатор	Potassium sodium tartrate tetrahydrate	$C_4H_4KNaO_6$	6381-59-5	1
37	PAN индикатор	1-(2-Pyridylazo)-2- naphthol	$C_{15}H_{11}N_3O$	85-85-8	0.5
38	S.S индикатор	Sulfosalicylic acid	$C_7H_5NaO_6S$	97-05-2	0.5
39	Мөнгөний нитрат	Silver nitrate	$AgNO_3$	7761-88-8	2
40	Натрийн хлорид	Sodium chloride	$NaCl$	7647-14-5	1
41	Сахароз	Sucrose	$C_{12}H_{22}O_{11}$	57-50-1	50
42	Зэсийн сульфат	Copper (II) sulfate	$CuSO_4 \cdot 5H_2O$	7758-98-7	5
43	Аммонийн монофосфат	Diammonium mono phosphate	$(NH_4)_2HPO_4$	7783-28-0	5
44	Калийн бромид	Potassium bromide	KBr	7758.02.03	2
45	Калийн иод	Potassium iodide	KI	7681-11-0	2
46	Устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxide	H_2O_2	7722-84-1	2
47	Хлорт кали	Potassium chloride	KCl	7447-40-7	3
48	Аммонийн нитрат	Ammonium nitrate	NH_4NO_3	6484-52-2	5
49	Хромын исэл	Chromium (III) oxide	Cr_2O_3	1308-38-9	5
50	Барийн хлорид	Barium chloride	$BaCl_2$	10361-37-2	10
51	Натрийн сульфат	Sodium sulfate	$Na_2SO_4 \cdot 7H_2O$	7757-82-6	5
52	Алюминий кали квасцы	Aluminum potassium sulfate dodecahydrate	$KAl(SO_4)_2 \cdot 12H_2O$	7784-24-9	5
53	Гидроксилламин соляно кислий	Hydroxileamine hydrochloride	$HONH_3Cl$	5470.11.1	2
54	Калийн нитрат	Potassium nitrate	KNO_3	7757-79-1	10
55	Аммоний надсерно кислий	Ammonium persulfate	$(NH_4)_2S_2O_8$	7727-54-0	2
56	Кали фтор	Potassium flouride	KF	7789-23-3	5

Handwritten signature and stamp at the bottom right of the page.



**Химийн бодисын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх
менежментийн төлөвлөгөөний тайлан-2023 он**

2023.11.08

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн	Тайлангийн биелэлт
1	Химийн хорт болон аюултай бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад зохих дүрэм, журмын дагуу хадгалж, ашиглаж, устгах үйл ажиллагааг аюулгүй зохион байгуулах	2023 онд	СШЛабораторийн эрхлэгч, ХАБЭАБОХ	2023 оны 3-р улирлын байдлаар химийн хорт болон аюултай бодисын агуулахын үйл ажиллагааг аюулгүй зохион байгуулаад ажиллаж байна.
2	Химийн хорт болон аюултай бодис хадгалах складыг зохих журмын дагуу ашиглаж, тогтмол хараа хяналттай, цоожтой байлгаж, хаалгыг лацдах.	тогтмол	Инженер /Аналитик/, Техникийн менежер, Нярав	Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг зохих журмын дагуу хариуцан эзэмшиж хянан ажиллаж байна.
3	Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дээр тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг харуулсан тод, том шошго зэргийг шинэчлэн хадаж байрлуулах	2023 он 1-р улиралд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Химийн хорт болон аюултай бодисын агуулахад байгаа химийн бодисын нэр хаягийг бүрэн тавьсан болно.
4	Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулах	тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Стандартад нийцсэн химийн бодисын агуулахыг ашигладаг болно.
5	Ажлын байран дээр ашиглагдаж байгаа химийн бодисуудыг хадгалж буй шүүгээ нь бат бөх болон хэт олон бодис дүүртэл хадгалсан эсэх, тавиур дээрх химийн бодисыг хана болон шаланд сайтар бэхлэгдсэн эсэхийг шалгаж аюулгүй байдлыг хангах	тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер, Инженер /Ээлжийн/	Ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
6	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилладаг ажилтан нарт болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх, анхны тусламж	Жилд 2 удаа	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Химийн хорт болон аюултай бодистой харьцан ажилладаг ажилтан нарт 2023 оны 09 сарын 22-нд

	үзүүлэх сургалтыг зохион байгуулах			88.5% ирцтэйгээр зохион байгуулсан болно.
7	Химийн хорт болон аюултай бодисын зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан, мэдээг Сайхан сумын Засаг даргад жил бүрийн 12-р сарын 15-ны дотор, Сэлэнгэ аймгийн БОАЖГ, БОАЖЯам руу тус тус дараа оны 1-р сард хүргүүлэх	Тухай бүрт	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Зарцуулалтын тайланг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр нь гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.
8	Нэр төрөл, шинж чанар, хэрэглэх заавар тодорхой бус химийн хорт болон аюултай бодисыг эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр ашиглахгүй байх	тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер	Химийн бодисын тусгай зөвшөөрөлд тусгагдсан, шинжилгээнд ашиглагддаг химийн бодисуудыг худалдан авч ашигладаг.
9	Химийн хортой бодисын хуванцар сав, аюултай хог хаягдлыг тухай бүрт гэрээт байгууллагад хүргүүлж, устгуулах	Жилд 2 удаа	“Цэцүүх” ХХК, Хангамжийн хэлтэс, СШЛ	2023 оны 04 сарын 06-ны өдөр “ЭЛЕМЕНТ” ХХК-тай Химийн хорт болон аюултай бодисын хаягдал тээвэрлэн устгах ажил гүйцэтгэх гэрээг байгуулан 40 жил хуримтлагдсан байсан хугацаа дууссан болон нэр хаяг тодорхойгүй химийн бодисыг устгуулсан болно.
10	Ашиглахгүй болсон химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг зөвшөөрөлтэй газраар, эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй аргаар холбогдох комиссыг байлцуулан устгаж, акт үйлдэх	2023 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/, Техникийн менежер, БОМЭргэжилтэн, мэргэжлийн байгууллага	

Тайлан гаргасан:

СШЛабораторийн эрхлэгч



/Р.Оюун-Эрдэнэ/

УРГАМЛАН НӨМРӨГИЙН СУДАЛГАА

Судалгааны арга зүй

Төслийн талбай нь ургамал газарзүйн тойргийн хувьд Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтдаг. Төслийн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг илрүүлэх судалгааны ажлын хүрээнд ургамлын хээрийн судалгааг 2023 оны 7-р сарын 20-23-ны өдрүүдэд гүйцэтгэж, нийт 7 цэгт зүйлийн бүрдэл бүртгэж, ургамалжлын бичиглэл хийж, дээж материал цуглуулав.

1. Ургамлын буюу геоботаникийн бичиглэлийг 100 м² талбайд хийж,

- Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох,
- Ургамлын бүрхэц тодорхойлох /халцгай, хад чулууны бүрхэц
- Ургац тодорхойлох

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн фото зургийг авахдаа 1м²-ын тор тавьж, эгц дээрээс нь авах бөгөөд фото зургийг тайланд оруулахдаа дараах мэдээллийн хамт бичсэн.

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тогтоох арга: Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо 100 м²/10м x 10м/ газрын дөрвөн өнцөгт нь ялгах тэмдэг тавьж, нэг өнцгөөс нөгөө өнцгийг чиглэн диагналдан явж тохиолдох бүх ургамлыг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн нэршлийг Монгол орны гуурст дээд ургамлын бүртгэл бичигт (И.А.Губанов, 1996) болон ургамал таних бичигт (В.И.Грубов, 2008) зааснаар нэрлэж, олон улсын СИ системийн нэршлээр филогенетик системийн дагуу жагсаан бичсэн.

Зүйлийн жагсаалт хийх үед танихгүй юм уу эргэлзээтэй ургамал тааралдвал цуглуулгад авч дугаар, болзолт нэр, хугацаа, ургамал цуглуулсан газар ба бэлчээрийн хэв шинжийн нэрийг жижиг цаасан дээр бичиж хавсаргав.

Бүрхэцийн хэмжээ		Зүйлийн баялгийн онцлог	Хоорондын зай, см
Кодоор	Хувь		
Сop ²⁻³	30 дээш	Нэн арвин	<20
Сop ¹	10-25	Арвин	20-40
Sp	5-10	Тармагдуу	40-100
SoI	1-5	Дунд зэрэг	100-150
R	1	Нэн ховор	>150

Друдегийн үнэлгээ

Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц, халцгай газар, хагд, хад чулууны хэмжээг тодорхойлох: Газрын гадарга дээрх ургамлан нөмрөгийн бүрхэц, халцгай газар, хайрга чулуу, хагдны хэмжээг тодорхойлохдоо: Л.Г.Раменскийн 1м²-ийн трансектын тороор ургамлан нөмрөгийн бүрхэц тодорхойлох уламжлалт аргыг хэрэглэсэн. Ажиглалтын талбай дотроо дурын цэгийг сонгон трансектын торыг ашиглан тодорхойлсон. Торны 1 нүд 1%-тай тэнцэнэ. Торны эгц дээрээс нь харж, зогсоо байдлаас хөрсний гадаргын бүрхцийг торны 1 нүдийг 1 хувь гэж тооцон нүд болгоноор тоолон ургамлын бүрхэц, халцгай газрын хэмжээ, хад чулууны хэмжээ, хагдны бүрхцийг хувилж гарган доорх нүдэнд бичсэн.

1.1. Бэлчээрийн талхагдал

Бэлчээрийн талхагдлыг ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт ба ургамлын тусгац бүрхэц болон ургацаар тодорхойлсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний

өөрчлөлтийг Друдегийн аргаар, ургамлын тусгац бүрхэвчийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлсон.

Бэлчээрийн талхагдлыг дараах 3 зэрэглэлд хуваасан. Үүнд:

1. Сул талхлагдсан
2. Дунд талхлагдсан
3. Хүчтэй талхлагдсан

Сул талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдлийн зонхилогч, дэд зонхилогч нь ценоз /бүлгэмдэл/ үүсгэх үүрэг өөрчлөгдөхгүй. Сул талхагдалд орсон бол бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт бага зэрэг орж, үетний тоо буурч, алаг өвсний тоо ихсэх хандлагатай.

Дунд зэрэг талхлагдсан бэлчээр: Зонхилогч ургамлын ариw багасаж, агь, ишгүй гичгэнэ /навтуул/, арзгар согсоолж, нэг наст шарилжууд ариw ихтэй ургана. Дунд талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч, ургамлын бүрхэц багасаж, бүрхцэд талхагдлын заагуур ургамлын ариw ихэссэн.

Их талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдэл зонхилогч ургамлууд цөөрөн ганц нэг болон сийрэгжиж оронд нь агь, адамсийн шарилж, ширэг улалж, амманы сэдэргэнэ зэрэг мал иддэггүй хог ургамлын ариw нэмэгдэнэ. Их талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо эрс цөөрч, тухайн бэлчээрт 2-3 талхагдлын заагуур ургамал давамгайлан зонхилогч болсон. Төслийн талбай ургамлан нөмрөгийн 7-н нэгж талбайд ангилагдах бөгөөд нийт газрын гадаргын ургамлын бүрхэц 52.2-71.6%, түүнээс хог ургамал 10.6-34.6%, хайрга чулуу багатай, халцгай газар 19.8-40.8% эзэлж байна.

1. Үетэн-алаг өвст (82/ УХ-II-2-1) бүлгэмдэлд (цэг 3) үетнээс Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), хог ургамлаас Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), Шүүрэн шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai) зэрэг нийт 4 овог, 6 төрлийн 8 зүйл ургамал ургасан, 1м²-д 5-8 зүйл тааралдаж байв. Үетэн-алаг өвст бүлгэмдлийн ургамлын бүрхэц 52.2%, түүнээс талхагдлын заагуур хог ургамал 32.6%, нийт бүрхцэд халцгай газар 47.8% байна.



Ургамлын бичиглэл цэг 1

Үетэн-алаг өвст бүлгэмдэл: Үетэн-алаг өвст бүлгэмдлийн ургац тодорхойлоход 3.124 ц/га, үүнээс үетэн 1.64 ц/га, алаг өвс 0.312 ц/га, шарилж 1.172 ц/га байна.


2. Агь шарилж-үетэнт (У-V-2-1) бүлгэмдэлд (цэг 6) шарилжаас Агь (*Artemisia frigida* Willd.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai), үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), алаг өвснөөс Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Эгэл цагаантүрүү (*Leontopodium leontopodioides* (Willd.) Beauvd.) зэрэг нийт 4 овог, 5 төрөл, 7 зүйл ургамал ургасан, 1м²-д 4-5 зүйл тааралдаж байв. Агь шарилж-үетэнт бүлгэмдлийн ургамлын бүрхэц 68.8%, түүнээс талхлагдлын заагуур хог ургамал 34.6%, нийт бүрхэцэд хайрга чулуу 5.2%, халцгай газар 31.2% байна.



Ургамлын бичиглэл цэг 2

Агь шарилж-үетэнт бүлгэмдэл: Агь шарилж-үетэнт бүлгэмдлийн ургац тодорхойлоход 2.742 ц/га, үүнээс үетэн 0.474 ц/га, навтуул зэрэг алаг өвс 1.032 ц/га, шарилж 1.236 ц/га байна.


3. Улалж-Агь шарилж-үетэн-харганат 56a(У-V-2-1) бүлгэмдэлд (цэг 2) улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A. Mey.), үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.), Shult.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin), Дагуур цагаан суль (*Elymus dahuricus* Turcz ex Griseb.), алаг өвснөөс Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), буурцагтнаас Тарваган харгана (*Caragana pumila* (L.) DC.), шарилжнаас Агь (*Artemisia frigida* Willd.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.) зэрэг нийт 5 овог, 10 төрлийн 11 зүйл ургамал ургасан, 1м²-д 5-8 зүйл тааралдаж байв. Улалж-Агь шарилж-үетэн-харганат бүлгэмдлийн ургамлын бүрхэц 71.4%, түүнээс талхлагдлын заагуур хог ургамал 10.6%, нийт бүрхэцэд хайрга чулуу 6.8%, халцгай газар 21.8% байна.



Ургамлын бичиглэл цэг 3

Улалж-Агь шарилж-үетэн-харганат бүлгэмдэл: Улалж-Агь шарилж-үетэн-харганат бүлгэмдлийн ургац тодорхойлоход 3.628 ц/га, үүнээс улалж 0.96 ц/га, үетэн 0.492 ц/га, алаг өвс 1.172 ц/га, шарилж 1.004 ц/га байна.

4. Улалж-үетэн-харганат (96/УХ-II--4-11) бүлгэмдэлд (цэг 1) улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* С.А.Мей.), үетнээс Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.), буурцагтнаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), алаг өвснөөс Үмхий буржгар (*Thalictrum foetidum* L.), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Bge.)Juz.), Арзгар согсоолж (*Heteropappus hispidus* (Thunbg.), шарилжаас Ишгэн шарилж (*Artemisia dracunculius* L.) зэрэг нийт 6 овог, 8 төрлийн 8 зүйл ургамал ургасан, 1м²-д 4-6 зүйл тааралдаж байв. Улалж-үетэн-харганат бүлгэмдлийн ургамлын бүрхэц хагдаа оруулаад 64.6%, түүнээс талхагдлын заагуур хог ургамал 24.4%, нийт бүрхцэд хайрга чулуугүй, халцгай газар 27.6% байна.



Ургамлын бичиглэл цэг 4

Улалж-үетэн-харганат бүлгэмдэл: Улалж-үетэн-харганат бүлгэмдлийн ургац тодорхойлоход 3.71 ц/га, үүнээс улалж 1.146 ц, үетэн 0.841 ц/га, алаг өвс 0.472 ц/га, харгана 1.25 цн байна.

5. Жижиг улалж-хиг-харганат (228а/Н-III-5-1) бүлгэмдэлд (цэг 4) улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* С.А.Мей.), үндэслэг ишт үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Соргүй согоовор (*Bromus inermis* Leyss.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.), алаг өвснөөс Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), буурцагтнаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.), цөөн настнаас Цэх түмэн тана (*Chamaerhodos erecta* (L) Bge.), Умардын далантовч (*Androsace septentrionalis* L.), Үмхий шимэлдэг (*Dracocephalum foetidum* Bge.) зэрэг нийт 9 овог, 11 төрлийн 11 зүйл ургамал ургасан, 1м²-д 6-8 зүйл тааралдаж байв. Хиаг-алаг өвст бүлгэмдлийн ургамлын бүрхэц 71.6%, түүнээс талхагдлын заагуур хог ургамал 22.2%, нийт бүрхэцэд хайрга чулуугүй, халцгай газар 19.8% байна.



Ургамлын бичиглэл цэг 5

Жижиг улалж-хиаг-харганат бүлгэмдэл: Жижиг улалж-хиаг-харганат бүлгэмдлийн ургац тодорхойлоход 3.488 ц/га, үүнээс улалж 1.56 ц/га, үетэн 0.944 ц/га, харгана 0.894 ц/га байна.

6. Үетэн-алаг өвс-агьт (85а/Х-I -2-9) бүлгэмдэлд (цэг 2) үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.) болон Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилж, алаг өвснөөс Нарийн навчит тарна (*Polygonum angustifolium* Pall.), Жавхаалаг Башир (*Dianthus superbus* L.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Хадны бөгтөргөнө (*Amblynotus rupestris* (Pall.) M. Pop.ex Serg.), цөөн наснаас Хогийн цангуу (*Lepidium ruderale* L.), Үмхий шимэлдэг (*Dracoscephalum foetidum* Bge.), шарилжаас Шүүрэн шарилж (*Artemisia scoraria* Waldst. et Kit), Ишгэн шарилж (*Artemisia dracunculus* L.) зэрэг нийт 8 овог, 101 төрлийн 12 зүйл ургамал ургасан, 1м²-д 4-6 зүйл тааралдаж байв. Хялгана-үетэн-алаг өвст бүлгэмдлийн ургамлын бүрхэц хагдаа оруулаад 59.6%, түүнээс талхагдлын заагуур хог ургамал 20.6%, нийт бүрхцэд хайрга чулуу 7.2%, халцгай газар 33.2% байна.



Ургамлын бичиглэл цэг 6

Үетэн-алаг өвс-агьт бүлгэмдэл: Үетэн-алаг өвс-агьт бүлгэмдлийн ургац тодорхойлоход 1.928 ц/га, үүнээс үетэн 0.81 ц/га, алаг өвс 0.514 ц/га, агь шарилж 0.604 ц/га байна.

7. Хиаг-алаг өвс-харганат (83а/УХ-II -1-2) (цэг 7) үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Дагуур цагаан суль (*Elymus dahuricus* Turch ex Griseb.), алаг өвснөөс Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana* С.А.Мey.), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), буурцагтнаас Бяцхан навчит харгана (*Caragana microphylla* (Pall.) Lam.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), хог ургамлаас Ээрэм шарилж (*Artemisia macrocephala* Jacquem), Гашуун банздоо (*Saussurea amara* DC.) зэрэг нийт 5 овог, 8 төрөл, 8 зүйл ургамал ургасан, 1м²-д 3-4 зүйл тааралдаж байв. Хиаг-алаг өвс-харганат ургамлын бүрхэц 59.2%, түүнээс талхагдлын заагуур ургамал 14.0%, нийт бүрхцэд халцгай газар 40.8% байна.



Ургамлын бичиглэл цэг 7

Хиаг-алаг өвс-харганат бүлгэмдэл: Хиаг-алаг өвс-харганат бүлгэмдлийн ургац тодорхойлоход 3.292 ц/га, үүнээс үетэн 1.836 ц/га, бусад алаг өвс, 0.366 ц/га, харгана зэрэг буурцагтан 1.09 ц/га байна.

1.2. Ургамлын бүтэц, бүрэлдэхүүний баялаг

Бид 2023 онд нийт 14 овог, 32 төрөл, 40 зүйл ургамал бүртгэв.

Бүртгээсэн ургамлын зүйлийн жагсаалт

№	Овог, төрөл, зүйлийн шинжлэх ухааны нэр	Арив, Друде	Цэг	Бэлчээр	Хог ургамал	1, 2 наст	олон наст	Заримдаг сөөгөнцөр,
1	Gramineae Juss. –Үетэний овог							
1	Stipa L.							
1	Stipa Krylovii Roshev.-Крыловын хялгана	COP 3	6	1			1	
2	Koeleria Pers.							
2	Koeleria macrantha (Ldb.), Shult.-Том цэцэгт дааган сүүл	COP 3	4	1			1	
3	Cleistogenes Keng.							
3	Cleistogenes squarrosa (Trin.)Keng.- Дэрвээн хазаар өвс	COP 1	1, 2,6	1			1	
4	Eragrostis Wolf.							
4	Eragrostis minor Host-Бара хургалж	COP 1	7	1	1	1		
5	Bromus L.							
5	Bromus inermis Leyss.-Соргүй согоовор	COP 1	5	1			1	
6	Poa L.							
6	Poa botryoides Trin.-Цацаглаг биелэг өвс	COP 1	4	1			1	
7	Agropyron Gaertn.							
7	Agropyron cristatum (L.) P.B.-Саман ерхөг	COP 1	1,6	1			1	
8	Elytrigia Desv.							
8	Elytrigia repens (L.) Desv. ex Nevski.- Мөлхөө хиаг	COP 3	1,2	1	1		1	

9	Elymus L.						
9	Elymus dahuricus Turch ex Griseb. - Даруур цагаан суль	COP 3	7	1			1
2	Cyperaceae Juss. – Улалжийн овог						
10	Carex L.						
10	Carex duriuscula С.А.Меу.-Ширэг улалж	COP 1	1, 3,6	1	1		1
3	Polygonaceae Juss. – Тарнын овог						
11	Polygonum L.						
11	Polygonum angustifolium Pall.- Нарийн навчит тарна	COP 3	6	1	1	1	
4	Chenopodiaceae Vent. – Луулийн овог						
12	Chenopodium L.						
12	Chenopodium glaucum L.-Хөх ногоон лууль	COP 3	6	1	1	1	
5	Caryophyllaceae Juss. –Башир цэцэгтэний овог						
13	Silene L.						
13	Silene repens Patr.- Мөлхөө шээрэнгэ	Sol	1	1	1		1
14	Dianthus L.						
14	Dianthus superbus L.-Жавхаалар Башир	Sp	6	1	1		1
6	Ranunculaceae Juss. – Холтсонцэцэгтэний овог						
15	Pulsatilla L.						
15	Pulsatilla Bungeana С.А.Меу.-Бунгийн яргуй	Sol	7	1			1
16	Thalictrum L.						
16	Thalictrum foetidum L.-Үмхий бужгар	COP 1	4	1	1		1
7	Cruciferae Juss. – Тоонолжинцэцэгтэний овог						
17	Lepidium L.						
17	Lepidium ruderale L. –Хогийн цангуу	COP 1	6		1	1	
8	Rosaceae Juss. –Сарнай цэцэгтэний овог						
18	Potentilla L.						
18	Potentilla bifurca L.-Имт гичгэнэ	COP 1	6	1	1		1
19	Potentilla acaulis L.-Ишгүй гичгэнэ	COP 1	2,3		1		1
19	Sibbaldianthe Juz.						
20	Sibbaldianthe adpressa (Vge.)Juz.- Налчгар хэрээн хошуу	COP 1	5	1	1		1
20	Chamaerhodos Vge.						
21	Chamaerhodos erecta (L) Vge.-Цэх түмэн тана	COP 1	5		1	1	
9	Leguminosae Juss. – Буурцагтаны овог						
21	Caragana Lam.						
22	Caragana pugnata (L.) DC.-Тарваган харгана	Sol	5	1	1		1
23	Caragana microphylla (Pall.) Lam.-Бяцхан навчит харгана	Sol	7	1	1		1
22	Astragalus L.						

24	<i>Astragalus adsurgens</i> Pall.-Нумраа хунчир	Sol	7	1	1		
10	Boraginaceae Juss. – Ноцоргонын овог						
23	<i>Amblynotus</i> Johnst.						
25	<i>Amblynotus rupestris</i> (Pall.) M. Pop.ex Serg.- Хадны бөгтөргөнө	Sol	7		1		1
24	<i>Lappula</i> Fabr.						
26	<i>Lappula intermedia</i> (Ldb.) M.Pop.- Завсрын ноцоргоно	COP 1	1		1	1	
11	Labiaceae Lindl.-Уруул цэцэгтэний овог						
25	<i>Dracosephalum</i> L.						
27	<i>Dracosephalum foetidum</i> Bge. - Үмхий шимэлдэг	COP 1	5		1	1	
12	Scrophulariaceae Juss. –Иршимбийн овог						
26	<i>Cymbaria</i> L.						
28	<i>Cymbaria dahurica</i> L.- Дагуур хатны цэцэг	Sol	1	1	1		1
13	Plantaginaceae Juss. – Тавансалааны овог						
27	<i>Plantago</i> L.						
29	<i>Plantago depressa</i> Willd.- Замын таван салаа	COP 1	5	1	1		1
14	Asteraceae Dumort. –Голгэсэртэний овог						
28	<i>Heteropappus</i> Less.						
30	<i>Heteropappus hispidus</i> (Thunbg.) Less.- Арзгар согсоолж	Sol	3	1	1		1
29	<i>Leontopodium</i> R. Br. ex Gass.						
31	<i>Leontopodium leontopodioides</i> (Willd.) Beauvd.-Эгэл цагаантүрүү	Sol	2	1			1
30	<i>Artemisia</i> L.						
32	<i>Artemisia dracunculus</i> L.-Ишгэн шарилж	COP 1	6	1	1		1
33	<i>Artemisia pectinata</i> Pall.-Шүлхий шарилж	COP 3	1		1	1	
34	<i>Artemisia macrocephala</i> Jacquem- Ээрэм шарилж	COP 1	7		1	1	
35	<i>Artemisia Sieversiana</i> Willd.- Сиверсийн шарилж	COP 1	2		1	1	
36	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.- Шүүрэн шарилж	COP 3	1	1	1	1	
37	<i>Artemisia frigida</i> Willd.-Агь	COP 2	2, 6	1	1		1
38	<i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai- Монгол шарилж	COP 3	1, 2		1		1
31	<i>Saussurea</i> DC.						
39	<i>Saussurea amara</i> DC.-Гашуун банздоо	COP 1	7		1	1	
32	<i>Taraxacum</i> Wigg.						
40	<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb. - Цуулбар багваахай	COP 1	6	1	1		1

14 овог, 32 төрөл, 40 зүйл

Тайлбар: 1., 2.... -ургамлын овгийн шинжлэх ухааны нэршил
1., 2.... -ургамлын төрлийн латин нэршил

1., 2....-ургамлын зүйлийн шинжлэх ухааны нэршил

1.3. Ургамлын ангиллын бүтэц, амьдралын хэлбэр

Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц. 2023 онд бүртгэсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд шивэрсэн, шивлээ, оймын нүцгэн үртэний хүрээний зүйл ургамалгүй, далд үртэний хүрээний 40 зүйл (үүнээс нэг талтан 120 зүйл, хос талтан 30 зүйл) ургаж байна.

Тус талбайд бүртгэсэн ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтэц

Ангиллын үндсэн бүлгүүдийн нэр	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн	
			тоо	эзлэх (%)
Далд үртний хүрээ, үүнээс:	14	32	40	100.00
а. Нэг талт үрт ургамлын анги	2	10	10	25.00
б. Хос талт үрт ургамлын анги	12	22	30	75.00


Энд бүртгэгдсэн ургамлаас голгэсэртэн, үетэн, сарнай, буурцагтны овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 4-д жагсаж байгаа бөгөөд бусад овгууд 1-2 зүйлтэй байна. Эхний 4 овогт багтах зүйл ургамлууд судалгааны талбай орчмын бүх зүйлийн ихэнхийг буюу 2023 онд 67.5% -ийг бүрдүүлж байна.

Зонхилох ургамлын овгууд, 2023 он

№	Овог	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь
1	<i>Asteraceae</i> Dumort. –Голгэсэртэний овог	5	11	27.5
2	<i>Gramineae</i> Juss. -Үетэний овог	9	9	22.5
3	<i>Rosaceae</i> Juss. –Сарнайн овог	3	4	10.0
4	<i>Leguminosae</i> Juss. – Буурцагтаны овог	2	3	7.5
	Бүх зүйлийн	19	27	67.5

1.3.1. Ургамлын амьдралын хэлбэр

2023 онд бүртгэсэн 40 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 28 зүйл олон наст өвслөг ургамал (70.00%), 9 зүйл нэг ба хоёр наст буюу цөөн наст ургамал (22.5%), Агь, харгана зэрэг 3 зүйл заримдаг сөөг (7.5%) эзэлж байна.



Амьдралын хэлбэр

Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Төслийн талбай дахь бүх зүйл ургамлаас 11 овгийн 28 төрлийн 30 зүйл бэлчээрийн (75.0%), 12 овгийн 16 төрлийн 20 зүйл эмийн ашигт ургамал (50.0%), 12 овгийн 17 төрлийн 21 зүйл хог ургамал (52.5%) бүртгэгдсэн байна.

Зүйлийн бүрдлийн онцлог

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	11	28	30	75.0%
Эмийн ашигт ургамал	12	16	20	50.0%
Хог ургамал	12	17	21	52.5%

1.4. Төслийн талбайн өнөөгийн төлөв байдал

1.4.1. Төслийн талбайн ургамлан нөмрөгийн доройтол

Бэлчээрийн талхагдлын зэргийг тогтоохдоо ургамлан нөмрөгт хог ургамал тархсан байдал болон Бэлчээр газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхагдлыг тодорхойлох” MNS 5546:2005 стандартыг харгалзан доройтлын гурван зэрэгт ангилан үзэв. Үүнд:

1. Хүчтэй доройтсон газар. Үндсэн бүлгэмдлийн ургамлууд нь уурхайн ашиглалтын нөлөөгөөр эвдэрч, ургамлан нөмрөггүй болж халцгай газар үүссэн **4.66 га (15.74%)** талбай байна.

2. Дунд доройтсон газар. Ашиглалтын болон байгаль цаг уурын нөлөөгөөр ургамлан нөмрөгт зонхилгогч ургамлын ариг багасаад шарилж, гичгэнэ, лууль зэрэг ургамлууд арви ихтэй ургасан, MNS 5546:2005 стандартын дагуу талхагдлын заагуур ургамал 3-4 зүйл болсон ургацын буурал 41-60% болсон байвал дунд доройтсонд хамруулж үзэхэд нийт **13.67 га (46.27%)** талбай байна.

3. Сул доройтсон газар. Үндсэн бүлгэмдлийн зонхилгогч, дэд зонхилгогч нь бүлгэмдэлдээ үүргээ алдаагүй боловч MNS 5546:2005 стандартын дагуу талхагдлын заагуур ургамал 2-4 зүйл болсон, ургацын буурал 20-40% болсон газрыг сул доройтсон гэж үзэв. Ийм газар **11.25 га (37.99%)** талбай хамаарч байна.

4. Эрүүл талхлагдаагүй соргог бэлчээр. Ургамлан бүлгэмдлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүтээмжид өөрчлөлт ороогүй, унаган байдлаараа байвал эрүүл хэвийн газарт оруулдаг бөгөөд ийм талбай алга байна.

Ургамлан нөмрөгийн доройтол

ID CO D	Бэлчээрийн төрөл	Талбай /га/	Ургамлын бүрхэц, хагдаа оруулаад, %	Халцгай газар, %	Талхлагдлын заагуур ургамлын эзлэх %	Ургац, ц/га	Доройтлын зэрэг
1	Үетэн –алаг өвст (82/ УХ-II-2-1)	4.13	52.2	48.8	32.6	3.124	Дунд
2	Жижиг улалж-хиаг-харганат (228a/H-III -5-1)	2.89	71.6	19.8	22.2	3.488	Дунд
3	Үетэн-алаг өвс-агьт (85a/X-I -2-9)	3.55	59.6	33.2	20.6	1.928	Дунд

4	Агь шарилж-үетэнт (У-V-2-1)	3.96	63.6	31.2	34.6	2.742	Дунд
5	Хиаг-алаг өвс-харганат (83а /УХ-II -1-2)	1.6	59.2	40.8	14.0	3.292	Сул
6	Улалж-Агь шарилж-үетэн-харганат 56а/(У-V-2-1)	5.08	71.4	21.8	10.6	3.628	Сул
7	Улалж-үетэн-харганат (96/УХ-II--4-11)	3.74	64.6	27.6	24.4	3.271	Дунд
0	Эвдэрсэн газар	4.66					Хүчтэй
	Нийт	29.61					

Хянасан:

БОХэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

З. Болортуяа

З.Болортуяа

Судалгаа гаргасан:

БОНСМэргэжилтэн

Т. Уртнасан

Т.Уртнасан

АМЬТНЫ АЙМГИЙН СУДАЛГАА

2023 оны 08 сарын 04 өдөр

Монгол орны ландшафтын мужлалд амьтны аймгийн чанарын болон тооны харьцааг баримтлан Умардын болон уулархаг Азийн гэсэн 2 дэд их мужид хуваажээ. Умардын дэд их мужид Тайгын муж ба түүний Дорно Сибирийн дэд муж байх бөгөөд түүнд Хөвсгөл болон Хэнтийн тойрог багтана. Уулархаг Азийн дэд их мужид Монгол, Төвөдийн муж багтана. Монгол, Төвөдийн мужийг дотор нь монгол хээрийн ба ойт хээрийн, говийн дэд муж гэж хуваасан байна.

Монгол орны нутаг дэвсгэр байгалийн газарзүйн хувьд нэн өвөрмөц онцлогтой учир бүс бүслүүр үүсгэж үүнд зохицон амьдрах амьтны аймаг нь ихээхэн баялаг бүрэлдэхүүнтэй юм. Иймд тус оронд өндөр уулын тагийн бүслүүрээс цөлийн бүс хүртэлх бүхий л бүс бүслүүрийн амьтад амьдрах нөхцөл бүрджээ. Говь цөлийн ландшафтад нутгийн уугуул буюу төв азийн унаган амьтад олноор амьдарна.

Амьтны аймгийн бүрэлдэхүүнд: хөхтөн, жигүүртэн, шавж, хэвлээр явагчид, усны амьтад зонхилсон бөгөөд нутгийн хойд хэсгийн уулархаг нутгийн ой тайгад амьдардаг хөхтөн амьтаас атаахай, оготно, олон зүйлийн туурайтан, махан идэштэн;

Ойт хээрийн бүсийн хээрт: нүх, үүр малтан орогнодог ногоон өвсөн тэжээлт, тарвага, бусад жижиг амьтад зонхилсон хөхтний бүлгэмдэл, харин хээрийн бүсийн зүүн захаар цагаан хээрийн сүрэг тархана.

Цөлөрхөг хээрийн ба цөлийн бүсэд: Монгол чичүүл, зарим зүйл алагдаахай, шишнүүхэй, үүнээс урагшаа болоход шар чичүүл зонхилно.

Монгол орны уудам нутгийн байгалийн байдал янз бүр буюу өндөр уул, хээр тал, ой мод, говь цөл хосолсны ачаар амьтны аймаг баялаг юм. Уул нурууд олон учраас босоо бүс бий болж, бүс бүслүүр дотор ч газар зүйн байдал өөр өөр байдаг болохоор янз бүрийн амьтад байрлан оршиход тохиромжтой нөхцөл бүрджээ. Монгол орны амьтны аймаг, нугаламт амьтдын зүйлийн хөхтөн 141, шувуу 502, загас 79, хоёр нутагтан 6, мөлхөгчид 22 зүйл буюу нийт 750 зүйл байна. Нугаламгүйтнээс зөөлөн биетэн 41, хорхой 86, үе хөлтөн 5128 амьтдын нийт 5255 зүйл бүртгэгдээд байна.

Монгол орны хөхтөн ховор, нэн ховор амьтад

Амьтдын хэв шинж	Хөхтөн		
	Түгээмэл	Ховордсон	Нэн ховор
Өндөр уул	Чандага, оготно, цагаан үен, унтаахай, бор гөрөөс	Аргаль, янгир	Ойн цаа буга, ирвэс
Ойн	Ойн хулгана, гахай, бор гөрөөс, солонго, чоно	Зэгсний гахай, шилүүс, халиу буга	Хүдэр, хадны суусар
Хээр	Зээр, үлийн цагаан оготно, туулай, мануул	Хар сүүлт	цөөвөр чоно
Говь-цөл	Зээр, алаг даага, туулай	Хулан, монгол бөхөн	мазаалай, хавтгай, тахь
Гол мөрөн, нуурын		минж, халиу	

Монгол орны жигүүртэн ховор, нэн ховор амьтад

Амьтдын шинж	хэв	Хөхтөн		
		Түгээмэл	Ховордсон	Нэн ховор
Өндөр уул		тас		бүргэд
Ойн		төншуул, хөхөө, сойр	шар шувуу	гургуул, ятуу
Хээр		болжмор, тагтаа, элээ	хойлог, шонхор	сар, тогоруу
Говь-цөл		ногтруу		
Гол мөрөн, нуурын		ангир	халбаган нугас, тогоруу	хотон, гангар хун

Судалгааны талбай орчмын амьтны аймгийн онцлог

Эдэлбэр газрын орчимд чоно ховор. Үнэг, хярс, солонго зэрэг амьтад элбэг тархалттай байна. Ялангуяа хярс, шар үнэг ховор биш байдлаар тархсан болохыг мөр, түр болон удаан хугацаагаар амьдардаг нүх мөн ард иргэд, байгаль хамгаалагчдын аман мэдээ, аймгийн ан амьтдын тайлан зэрэг материалаар тодорхой байна. Тэдгээрийн гол хоол тэжээл болох үлийн цагаан оготно, үхэр огдой, урт сүүлт зурам, бор туулай зэрэг өвс идэшт жижиг амьтад элбэг бус өөрөөр хэлбэл экологийн тэнцвэрт байдлыг хангасан байдалтай оршиж байна.

1. Хөхтөн амьтад

Судалгааны талбайн нэг га талбайд 2-4 бодгалиар тоологдож байна. Үлийн цагаан хулганы "үлий" үүр 1 га-д 4-6 ш тоологдов. Үүнээс үзэхэд нягтшилын хувьд "багаас дунд" зэргийн түвшинд байна. Ер нь эл оготны хувьд Монголын ойт хээрийн өмнө, хуурай хээр, говийн бүс нутагт өргөн тархсан, тоо толгой буурахгүй харин ч жилээс жилд нэмэгдэж байгаа. Мөн монгол чичүүл нь төслийн талбайн хил татсан шуудууны овоолсон шороонд байдаг байна.

Монгол чичүүл нь нэг га талбайд 1-3 бодгаль тоологдож байна. Мөн энэ нь түгээмэл тархацтай амьтан биш юм. Өөрөөр хэлбэл ухсан шуудууны зөөлөн сул шороотой далан, айлын бууц, төмөр замын далан гэх мэт газарт байж байгаад шилжилт хөдөлгөөн хийдэг нь үхэл хорогдолтой амьтан болохыг харуулж байна.

Судалгааны талбайн хойд хэсэг уулархаг өндөрлөг хад чулуутай бөгөөд гүн гуу жалга бүхий газарт урт сүүлт зурам, үхэр огдойн тархалт элбэг бус ч гэсэн тархай сийрэг байдлаар амьдарч байна. Судалгааны хугацаанд нэг га талбайд 1-3 бодгаль тоологдож байна.



Саарал чоно



Шар үнэг



Урт сүүлт зурам



Монгол чичүүл

Бор туулайны хувьд элбэг талдаа. Монгол орны ойт хээр, уулархаг хээр, тал хөдий гээд их өргөн уудам нутагт түгээмэл тархсан амьтны нэг юм. Харин тарвага нь судалгааны талбайгаас зүүн урагш 13-16 км-ын зайд орших "Баюдай" ууланд байдаг. Тоо толгойн хувьд эрс багассан, орон нутгийн үнэлгээгээр устаж болзошгүй амьтны тоонд бүртгэгдээд сүүлийн 5 жил агнахыг хориглосон тухай ярьж байсан. Тарваганаас бусад дээр дурдсан өвс идэшт жижиг амьтад бүс нутгийн үнэлгээгээр анхааралд өртөөгүй амьтад бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин ч махчин амьтад болон шувуудын идэш тэжээлийн холбоо болдог ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл экологийн тэнцвэрт байдлыг хангаж, хөрсийг сийрүүлэх, хөрсний өнгөн болон гүний шороог холих, агаар сэлгэх, хөрсөн дэхь шимт бодсыг нэмэгдүүлэх, эргэлтэд оруулж байдаг.

2. Шувууд

Судалгааны талбайд суурин шувуудаас индемик гарал үүсэлтэй бүргэд, харцага, сар, хон хэрээ, хар хэрээ, шаазгай, улаан хошуу, тагтаа, бор болжмор зэрэг шувууд элбэг тархалттай байна. Мөн нүүдлийн шувууд үзэгдэх нь ховор бөгөөд намар болон хавар нүүдлийн шувууд буцах ирэх үед л хааяа нисэж байгаа нь харагддаг гэж байгаль хамгаалагчид ярьж байна. Харин сохор элээ, алагтуу шувуу төв, суурин, хөдөө хээр газарт түгээмэл бий.

Идлэг шонхор, сар, харцага зэрэг шувууд нь голчлон үлийн цагаан оготно болон бусад жижиг мэрэгч хулганаар хооллодог. Харин бүргэд нь тарвага, зурам, хулгана зэрэг амьтдыг барьж иддэг байна. Мөн элээ, хэрээ, шаазгай, улаан хошуу, алагтуу зэрэг шувууд нь дулааны улиралд шавжаар хооллоно.

Суурин шувууд



Хар хэрээ



Шаазгай

Нүүдлийн шувууд



Сохор элээ



Алагтуу

Хянасан:
БОХэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Судалгаа гаргасан:
БОНСМэргэжилтэн

З. Галдурцаа

Т.Уртнасан

З.Болортуяа

Т.Уртнасан